

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС АГЕНТЛАГ, СУМДЫН  
2017 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.12.04

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 11 дүгээр сард 1 удаа хуралдаж 3 асуудал хэлэлцэн Сүхбаатар, Мандал сумдын агаар, орчны бохирдлыг бууруулах ерөнхий төлөвлөгөөний төсөл, “Эрчимжсэн үхрийн аж ахуй” аймгийн хөтөлбөрийн төсөл, Аймгийн 2017 оны тодотгосон төсвийг хэлэлцэн баталлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тайлант сард 2 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ.

Монгол Улсад Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсэж хөгжсний 25 жилийн ойг Сэлэнгэ аймагт тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэрийг гаргаж, зохион байгуулах ажлын төлөвлөгөө, аймгийн ИТХ, Засаг даргадах олгох шагналын журмыг шинэчлэн баталж, аймгийн ИТХ-ын ээжит 8-р хуралдааны товыг тогтоосон.

Мөн эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалан, хууль хяналтын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг Монгол Улсын цол, одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлан материалыг хүргүүлэв. Үүнд: МУ-ын Гавьяат цолоор 2, Алтан гадас одонгоор 3, Цэргийн хүндэт медалиар 1 иргэнийг тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид материалыг уламжлан хүргүүлэхээр шийдвэрлэж, Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсний 25 жилийн ой, орчин цагийн архив үүсэж хөгжсний 90 жилийн ой, аймгийн Биеийн тамир, спортын газар байгуулагдсаны 70 жилийн ойг тус тус тохиолдуулан улсад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг Сэлэнгэ аймгийн Хүндэт тэмдэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүндэт өргөмжлөлөөр шагнав.

Бүгд найрамдах Энэтхэг улсад зохион байгуулагдах Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах боксын тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн оролцох боксын “Улаан ирвэс” клубын тамирчин Д.Хонгорзулд 1915000 төгрөгийн дэмжлэг үзүүлж зардлыг аймгийн ИТХ-ын төсвөөс гаргахаар шийдвэрлэсэн.

**2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран ногоочдод зориулсан “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын хүрээнд Монголын хүлэмжийн фермер хөгжүүлэгчдийн нийгэмлэгийн тэргүүн Х.Алтанцацралт “Өвлийн хүлэмж барих арга”, “Мөнх ногоон амьдрал” ТББ-ын агрономич С.Тунгалаг “Хүлэмжинд жимс, хүнсний ногоо тариалах технологи”, БИОС нийгэмлэгийн тэргүүн Д.Тэгшжаргал “Хүнсний ногооны өвчин хортонтой тэмцэх арга”, УГТХ-ийн Хүнсний ногооны секторын эрхлэгч Н.Нарангэрэл “Хүнсний ногоо тариалах агро зөвлөмж, үр үржүүлэх боломж”, УГТХ-ийн хүнсний ногооны эрдэм шинжилгээний ажилтан Н.Одончимэг “Бага тархацын ногооны үрслэг бойжуулах арга, ургалтын хугацааны арчилгаа” сэдвүүдээр ногоочдод мэдээлэл өгч, 17 сумын Засаг дарга, ногоочдын төлөөлөл 180 гаруй хүн оролцлоо.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээс 100 тн өвс, 30 хүчит тэжээл бэлтгэсэн нь 83.5 хувь, сумын нөөцөд 1700 тн өвс, 510 тн тэжээл бэлтгэхээс 1100 тн өвс, 223 тн тэжээл бэлгэж 54.5 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Мандал, Сайхан, суманд инженерийн хийцтэй нэг худаг, малчдын санаачлагаар 9 суманд 20 энгийн уурхайн худаг гаргаад

байна. 2017-2018 оны өвөл хавар бэлчээрт 3051 инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг ашиглагдах бөгөөд худгийн бэлэн байдал 96.4 хувь, өрхийн усан хангамж 89.8 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газраас 11-р сарын 1-ний өдөр зохион байгуулсан цахим хурлаас өгөгдсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгаврыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс, албад, сумдын Засаг дарга нарт хүргүүлэн чиглэл өгч, салбарын сайдуудаас аймгийн Засаг даргатай 2017 онд байгуулсан гэрээний биелэлтийг урьдчилсан гүйцэтгэлээр гарган 2018 оны гэрээнд тусгах саналын хамт холбогдох яамдад хүргүүллээ.

Иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэх, төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаарх бүхий л мэдээллийг багтаасан, санал, өргөдөл, гомдлоо төрийн байгууллагуудад цахимаар гаргах боломж бүхий ухаалаг утсанд зориулсан “Нээлттэй Сэлэнгэ” аппликэйшнийг хэрэглээнд нэвтрүүлээ.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн байцаах албаны дар тус аймагт ажиллаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн дэд зөвлөлийн 3 гишүүнтэй гэрээ байгуулж, ажлыг нь эхлүүлэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын явц болон орон нутаг дахь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг газар дээр нь шалган танилцаж, аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 14 агентлаг, 5 суманд ажиллаж байгууллагуудын албан тушаалтнуудын гаргасан тушаал шийдвэр, дагаж мөрдөж буй дүрэм, журам, төлбөр хураамж тогтоосон баримт бичиг, төсөв санхүү, тусгай зөвшөөрлүүд, худалдан авалтын үйл ажиллагаанд шалгалт хийлээ.

Монгол Улсад орчин цагийн Архивын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг 11 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн төв Сүхбаатар суманд амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд “Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалт” хийж, сумдын төр төсвийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан 53, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын 51, нийт 104 архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан хамрагдлаа. Мөн хөмрөг үүсгэгч байгууллагуудын дунд “Тэргүүний архив” болзолт уралдаан, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын дунд “Архивч-2017” ажил мэргэжлийн тэмцээн, Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд “Архив, бидний нүдээр” эссэ бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулж үр дүнг тооцон ажиллалаа. Ойн баярын үеэр “Сэлэнгэ сайхан нутаг” үзэсгэлэн гаргаж олны хүртээл болголоо.

Сэлэнгэ аймагт Биеийн тамир спортын байгууллага үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээ 11-р сарын 25-ны өдөр боллоо. Аймгийн Биеийн тамир спортын газар нь анх 1947 онд Хөдөлмөрчдийн Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дэргэдэх Биеийн тамир спортын хороо нэртэйгээр байгуулагдсан бөгөөд ойн арга хэмжээний хүрээнд МУГТ Д.Оюунболд агсны хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүлж, үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулсан. Барилдаанд МУ-ын аварга Г.Эрхэмбаяр тэргүүтэй Сэлэнгэ аймгийн “Таван хан” бөхийн дэвжээний бөхчүүд хүрэлцэн ирж барилдан МУ-ын аварга Г.Эрхэмбаяр түрүүлж, улсын харцага Б.Одгэрэл үзүүрлэлээ. Энэ үеэр аймгийн БТСГ-ий дэд зөвлөл “Усан спорт сургалтын төв”-ийг албан ёсоор нээж, усан спортын зэрэгтэй тамирчдын үзүүлэх сургууль боллоо. Энэхүү “Усан спорт сургалтын төв” нь нэгд 1000 м<sup>2</sup>, 3 өрөөн, 300 м<sup>2</sup> өрөөн, 3, 5, 7 метрийн 3 өрөөн, нарийн 8 дүрэмт, 8 дүрэмт агаарын 2 дүрэмт, агаарын өргөгдөл 1 үйлдвэр, уралдаан тэмцээн сургалт явуулах 4 өрөөн юм.

**Онцгой байдлын талаар:**

“Авто үйлчилгээний байгууллага”-уудад Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалт, нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд, Баянгол, Мандал, Сайхан зэрэг сумдад үйл ажиллагаа явуулж байгаа авто засвар, авто сэлбэг, авто угаалга зэрэг 21 аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 58 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 15 үйлдэж аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад хүргүүлээ.

Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр ангийн захирагчийн баталсан “Гэр хорооллын айл өрхийн цахилгааны шугам сүлжээ, цахилгаан хэрэгслийн галын аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу Баянгол сум дахь Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн Баянгол сум Хараа 1, Баян 2, Гонир 3 дугаар багийн айл өрхөөр галын аюулаас урьдчилан сэргийлэх шалгалтыг зохион байгууллаа. Удирдамжит ажлын хүрээнд салааны алба хаагчид цахилгаан утасны холболтын аюулгүй байдлыг шалгаж, сэрэмжлүүлэг мэдээ, анхааруулга, санамж зөвлөгөөг хүргэлээ.

Шалгалтаар нийт 480 айл өрх хамрагдаж 950 гаруй хүнд ухуулга яриа сэрэмжлүүлэг, гарын авлага хүргэн илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь буюу хугацаатай арилгуулахаар шийдвэрлэн, шалгалтаар ажилласан тухай фото зургаар баримтжуулан ажиллаа. Нийт 180 гаруй зөрчлийг илрүүлэн, газар дээр нь 67 зөрчлийг арилгуулан ажилласан байна.

**Хяналт шалгалтын ажлын харьцуулалт**

| ᠰᠢᠵᠡᠭᠡᠭᠦᠨ            | Үсэүя<br>ø àèäëòàí ä<br>хамрагдсан |          | ᠴᠣ ᠳᠡᠭᠡ  |            | Àè-ñýí ýᠳᠦ ᠴᠵᠡí<br>áè-èäáàᠳᠡì ò |          |            |         |     |             | ᠮᠣᠶᠢ ᠠᠨᠠᠢ ᠴᠣᠳᠠᠭᠠᠳᠦ ᠨᠦᠭᠡ |
|----------------------|------------------------------------|----------|----------|------------|---------------------------------|----------|------------|---------|-----|-------------|-------------------------|
|                      | ᠠᠠᠢ ᠠ                              | ᠠᠡᠡ ᠣ ᠳᠦ | ᠡᠡᠳᠡᠵᠡᠨᠢ | ᠠᠳᠡᠡᠶᠣᠡᠨᠠᠢ | ᠴᠠᠠᠳ                            | ᠢ ᠶᠠᠶᠠᠶᠡ | ᠳᠠᠢ ᠡᠡᠣᠣᠡᠠ | ᠠᠵᠠ ᠶᠡᠨ | ᠠᠡᠡ | ᠠᠴᠣᠷ ᠠᠢ ᠢ ᠡ |                         |
| 2016 оны<br>11-р сар | 41                                 |          | 110      | 35         | 21                              | 19       | 1          | 2       | 2   | 1           | 5                       |
| 2017 оны<br>11-р сар | 21                                 |          | 58       | 14         | 6                               | 15       | -          | -       | -   | -           | 1                       |

2017 оны 11 дүгээр сард 6 удаагийн объектын гал түймэр гарсанаас, 4 гал түймэр дээр гал түймэр унтраах, аврах анги ажиллаж иргэд 2 гал түймрийг унтраасан байна. Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны угсралтын буруугаас 1, цахилгаан техникийн ашиглалтын буруугаас-1, пийшин зуух яндангийн цонолтоос 1, лаа дэн тамхи чүдэнзний галаас 1, ил задгай асгасан үнс нурамнаас 2 удаа тохиолдсон байна.

**Гал түймрийн нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:**

| д/д | Гал түймрийн төрөл | 2016 оны 11 дүгээр сар | 2017 оны 11 дүгээр сар | Өссөн, буурсан |
|-----|--------------------|------------------------|------------------------|----------------|
| 1   | Объектын           | 11                     | 6                      | 5-аар буурсан  |

Мандал сумын Минжийн хангайн 7-р баг “Минжийн хангайн 42 тоотод оршин суух иргэн Л.Даваагийн 10 толгой үхрийн 5 үхэрт шүлс гоожих, хэлний арьс хуулах, хөл нь доглох шинж тэмдэг илэрсэн тухай мэдээг 2017.11.17-ны 17:20 цагт хүлээн авч улсын мал эмнэлэгийн ариун цэврийн төв лабораторийн 2017.11.18-ны өдрийн 17-2433 дугаар шинжилгээний дүнгээр “шүлхий” өвчнөөр өвчилсэн болох нь тогтоогдсон. Улсын Онцгой комиссын 2017.11.20-ны 152, 153 дугаар Зам тээврийн хөгжлийн Сайд, Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яамны төрийн бичгийн дарга нарт “Хөдөлгөөн хязгаарлах”, “Үйл ажиллагааг түр зогсоох тухай” албан бичгүүд хүргэгдсэний дагуу Мандал сумын төмөр замын Галт тэрэгний хөдөлгөөн, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг тус тус зогсоосон байна. 72 айл өрхөөс дуудлага ирж 370 толгой үхэрт өвчний шинж тэмдэг илэрсэн гэх дуудлага ирсэнээс 60 айлын 1261 үхэрт үзлэг хийж, 340 үхрийг тусгаарласан. 4 хүний бүрэлдэхүүнтэй 1 баг ажиллаж, 5 айлын 1650 м2 талбайд, 7300 литр усаар ариутгал халдваргүйжилэлт хийсэн.

Баянгол сумаас Мандалын чиглэлд буюу Бороогийн уулзварт “Хүн чулуун”-ний, “Холбоо толгой”-ийн, “Шивэр”-ийн “Бөөбулаг”-ийн даваа “Зараа” толгой, “Ажнай”-н даваа гэх зэрэг 6 хяналтын цэгт Онцгой байдлын албанаас 6, Цагдаагийн байгууллагаас 6, Орон нутгаас ариутгал халдваргүйжүүлэлт хийх 6 иргэн үүрэг гүйцэтгэж байна. Мандал сум дахь 3 хяналтын байнгын цэг болон хөдөлгөөнт эргүүлд ажиллаж байгаа албан хаагч нар 38 автомашиныг шалгаж, “Хорио цээрийн дэглэм” зөрчсөн 1 тээврийн хэрэгсэл /жолооч/, 1 малчин иргэнийг тус тус зөрчлийн тухай хууль тогтоомжийн дагуу нийт 300.000 төгрөгний торгууль ногдуулсан. Сумын Онцгой комиссоос хорио цээрийн дэглэм тогтоосон үед байнгын болон түр зөвшөөрөлгүйгээр замын хөдөлгөөнд оролцсон 47 жолоочийг бүртгэлд авч, дахин энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар бичгээр баталгаа гаргуулан авсан

### **Мэргэжлийн хяналтын талаар:**

Мандал суманд малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан аймгийн хэмжээнд нийт 103 хүнсний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийж, хүн олноор цуглардаг нийтийн үйлчилгээний газар сургууль, цэцэрлэгийн орчимд ариутгал халдваргүйжүүлэлт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. Архи согтууруулах ундаа түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй 60 гаруй аж ахуй нэгж, байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж хууль журам зөрчин ажиллаж байсан аж ахуйн нэгжүүдэд улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллалаа.

Малын гоц халдварт шүлхий өвчинд мэдрэмтгий мал, амьтанд 1-р тун вакциныг Мандал суманд 33409, Сайхан суманд 13013, Орхон суманд 3000, Баянгол суманд 18389 нийт 67811 тун вакциныг зааврын дагуу хийж байгаа байдал, хадгалалт, тээвэрлэлтийн байдалд газар дээр нь очиж хяналт тавин ажиллаж, хадгалалт, хамгаалалтанд байгаа вакцин нь +2 хэмээс +8 хэмийн хооронд байгаа нь хүйтэн хэлхээний горим алдагдаагүй, зориулалтын хөргүүр ашиглаж чанар аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг ханган ажиллаж байна. Малын гоц халдварт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх хөнгөн цагааны усан исэлт давтан тун вакциныг 2017 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн хийхээр төлөвлөн бэлтгээд байна.


Мөн Малын гоц халдварт өвчний вакцин хийлгэсэн мал болон малын мах бэлтгэн хот суурин газарт нийлүүлж болзошгүй асуудлаар сумдын засаг дарга нарт холбогдох зөвлөмж боловсруулан хүргүүлж хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж, Мандал суманд орон нутгаас бэлтгэсэн өвс тэжээл, болон голомтоос ирсэн ард иргэдийн эд зүйлс, тээврийн хэрэгслийн ариутгал халдваргүйжүүлэлтэд анхаарч Ариутгалын 2 баг 128 айлын 67685 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгээд байна.

2018 оны төлөвлөлтөд эрсдэл өндөртэй эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр их дунд үнэлэгдсэн нийт 1004 объектод шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөн ажиллалаа. Хяналт шалгалтанд 669, зөвлөн туслах үйлчилгээнд 335, хамтарсан хяналт шалгалтаар 402 объектыг тус тус хамруулахаар төлөвлөж байгууллагын төсөв санхүү хөрөнгө мөнгөтэй уялдуулан гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр тусган ажиллалаа.

Сүхбаатар сумын 1, 2 дугаар сургуулиудын бага ангийн сургалтын хөтөлбөрт тандалт судалгаа хийж Монгол Улсын БСШУ-ны сайдын 471 дүгээр тушаалаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай журамд заасан "...суралцагчдад өгөх нэг өдрийн гэрийн даалгаврын хэмжээг сургалтын агуулга, суралцагчийн нас, бие, хөгжлийн онцлог, ачааллыг харгалзан 1 дүгээр ангид 1 хүртэл цаг, 2-3 дугаар ангид 1.5 цаг, 4-5 дугаар ангид 2 цаг, дунд ангид 2.5-3 цаг, ахлах ангид 3.5 цагаас ихгүй байхаар зохицуулсан" заалтыг зөрчиж, бага ангийн хүүхдэд гэрийн даалгаврыг хэт ачаалалтай өгсөн зөрчил нийтлэг илэрсэн тул зөвлөмж өгч, цаашид сумын 3, 4, 5, 6 дугаар сургуулиудыг тандалт судалгаанд хамруулахаар ажиллаж байна.

Замын тээвэрлэлтэд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, мөсөн давхрага үүссэн газруудад давс болон хайлуулах бодисуудыг цацаж байгаад хяналт тавьж, барилгын угсралтын ажлыг 2017 оны 11-р сарын 1-ний өдрөөс бүрэн зогсоосон.

Газрын итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 35 аж ахуйн нэгжийн 117 дээжинд 661 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 8 аж ахуйн нэгжийн 40 дээж 46 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй үр дүнтэй гарч нийт дээжийн 34,2 % -г эзлэж байна.



### **Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:**

“Дэлхийн Стандартын өдөр”, Үндэсний Чанарын 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Мандал сумын худалдаа үйлчилгээний 40 ажилтанд сургалт мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулж, “Худалдааны газар, түүний үйлчилгээ”, “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтонд тавих шаардлага”, “Хэмжил зүйн талаарх мэдээлэл”, “Үйлчилгээний ажилтны мэргэжлийн ёс зүй, соёл”, “Худалдааны салбарын өнөөгийн байдал хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвүүдээр мэдээлэл өгч хүнсний аюулгүй байдлыг хангуулах, стандарт, баталгаажуулалт, хэмжилзүйн талаарх гарын авлага тараах материалаар хангалаа. Мөн тухайн сургалтын талаар болон цаашид ямар сургалт мэдээлэл авах хүсэлтэй байгаа талаар санал асуулгын хуудсаар санал авсан нь цаашдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой ажил боллоо. Мөн Мандал сум, Түнхэл, Хэрх тосгоны худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн дунд үйлчилгээний ажилтны

мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага судлах зорилгоор “Ур чадвартай хамт олон” сэдэвт ажил мэргэжлийн уралдаан тэмцээнийг явуулж, худалдаа, үйлчилгээний газрын 4 баг оролцсноос “Ган зам” худалдааны газрын “Мөнгөн хараа” баг тэргүүлээ. Энэхүү ажил мэргэжлийн тэмцээн нь худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажлын туршлага солилцох, суралцах, цаашлаад салбарын хамт олныг ойртуулан нягтруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

2016-2017 онд иргэдээс авсан санал асуулга болон “Идэжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө”-ийн хүрээнд иргэдээс гаргасан анхаарал татсан асуудлын нэг цахилгааны хэмжүүр тоолуурт итгэлгүй байгаа талаарх гомдол, санал, Сүхбаатар сумын иргэдийн үндэслэл, аж ахуйн нэгж, байгууллагын өдөр тутмын үйлчилгээний цахилгааны нэг болон гурван фазын тоолуурын үйлчилгээний үйлчилгээний төлөвлөгөөний хүрээнд иргэдийн үндэслэл, аж ахуйн нэгж, байгууллагын өдөр тутмын үйлчилгээний цахилгааны нэг болон гурван фазын тоолуурын үйлчилгээний төлөвлөгөөний хүрээнд иргэдийн үндэслэл зорилгоор Мэргэжлийн хяналтын газрын Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч, Стандарт, хэмжилзүйн хэлтсийн улсын шалгагч нар хангагч, хэрэглэгчийн төлөөллийг байлцуулан шалгалт хийж, 42 аж ахуй нэгж, байгууллага айл өрхийн 43 цахилгааны тоолуурыг хамрууллаа.

Тайлант хугацаанд Баянгол, Мандал, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Хушаат, Жавхлант, Ерөө, Сүхбаатар сум, Хэрх, Түнхэл тосгонд ээлжит баталгаажуулалтаар ажиллаж, 41 аж ахуйн нэгжийн 44 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 36 худалдаа, үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо. Шаамар сумын 1 аж ахуйн нэгжийн 1 нэрийн 1 бүтээгдэхүүн, Сүхбаатар сумын 1 иргэний 1 нэрийн 2 бүтээгдэхүүн, Мандал сумын 1 иргэний 1 нэрийн 3 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж, Мандал сумын иргэн П.Равдандашийн үйлдвэрлэж буй хатаасан цоохор майлзыг стандартын шаардлага хангасан сав баглаа, хаяг шошготой болгох, цоохор майлзыг тариалах, хатаах, савлах технологийн ажиллагааг МУ-ын Оюуны өмчийн газрын Патентийн газарт бүртгүүлж гэрчилгээжих ажилд арга зүйн туслалцаа үзүүлсэн.

Стандартын салбар сангаас 6 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 8 нэрийн 9 стандартын борлуулалт хийж, 1 аж ахуй нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу 2 нэрийн 2 стандартаар хангах үйлчилгээ үзүүлсэн байна.

### **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль Улсын Их Хурлаар 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсантай холбогдуулан Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 33 дугаар тогтоолоор аймгийн тодотгосон төсвийн нийт орлого, зарлагыг 67.5 тэрбум төгрөгөөр баталсан. Мөн Улсын Их Хурлаас 2017 оны 11 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 8.5.2 болон 64.1.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалтыг үндэслэн Сэлэнгэ аймгийн 2018 оны төсвийн төслийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд аймгийн төсвийн нийт орлого, зарлагыг 71'069.9 мянган төгрөгөөр өргөн мэдүүлсэн.

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

| Д/д | Үзүүлэлтүүд                      | Төлөвлөгөө /мян.төг/ | Гүйцэтгэл /мян.төг/ | Хувь  |
|-----|----------------------------------|----------------------|---------------------|-------|
| 1   | Орон нутгийн төсвийн нийт орлого |                      |                     | 107.4 |

|          |  |                     |                     |              |
|----------|--|---------------------|---------------------|--------------|
|          |  | 17,190,263.0        | 18,456,642.1        |              |
|          | Үүнээс: Аймгийн төсвийн орлого                               |                     |                     | 95.7         |
|          |  | 10,892,868.5        | 10,420,104.0        |              |
| <b>2</b> | Орон нутгийн төсвийн нийт зарлага                            | 63,911,025.6        | 58,109,170.6        | 90.9         |
|          | - Аймгийн төсвийн зарлагын дүн                               | 15,314,497.6        | 13,425,763.1        | 87.7         |
|          | - Аймгийн ОНХСангийн зарцуулалт                              | 585,697.3           | 517,676.2           | 88.4         |
|          | - Аймгийн авто замын хөрөнгө оруулалт                        | 941,578.5           | 293,479.9           | 31.2         |
|          | - Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт              | 1,626,976.1         | 1,271,855.9         | 78.2         |
| <b>3</b> | Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг           | 1,886,108.2         | 1,886,108.1         | 100.0        |
| <b>4</b> | Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг                     | 2,900,000.0         | 2,900,000.0         | 100.0        |
| <b>5</b> | Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг           | <b>36,818,853.3</b> | <b>36,818,853.3</b> | <b>100.0</b> |
|          | - Ерөнхий боловсролын сургууль                               | 19,267,629.3        | 19,267,629.3        | 100.0        |
|          | - Хүүхдийн цэцэрлэг  | 9,433,948.3         | 9,433,948.3         | 100.0        |
|          | - Соёлын байгууллага   | 2,428,874.4         | 2,428,874.4         | 100.0        |
|          | - Биеийн тамир спортын байгууллага                           | 742,500.5           | 742,500.5           | 100.0        |
|          | - Эрүүл мэндийн байгууллага                                  | 4,506,195.2         | 4,506,195.2         | 100.0        |
|          | - ГХБХБГазар   | 188,016.8           | 188,016.8           | 100.0        |
|          | - ГБХЗХГазар   | 251,688.8           | 251,688.8           | 100.0        |
| <b>6</b> | Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | <b>36,818,853.3</b> | <b>36,818,853.3</b> | <b>100.0</b> |
|          | - Ерөнхий боловсролын сургууль                               | 19,267,629.3        | 19,267,629.3        | 100.0        |
|          | - Хүүхдийн цэцэрлэг  | 9,433,948.3         | 9,433,948.3         | 100.0        |
|          | - Соёлын байгууллага   | 2,428,874.4         | 2,428,874.4         | 100.0        |
|          | - Биеийн тамир спортын байгууллага                           | 742,500.5           | 742,500.5           | 100.0        |
|          | - Эрүүл мэндийн байгууллага                                  | 4,506,195.2         | 4,506,195.2         | 100.0        |
|          | - ГХБХБГазар   | 188,016.8           | 188,016.8           | 100.0        |
|          | - ГБХЗХГазар   | 251,688.8           | 251,688.8           | 100.0        |
| <b>7</b> | Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг                            | 2,870,186.6         | 2,882,198.0         | 100.4        |

|    |  |             |             |       |
|----|--|-------------|-------------|-------|
| 8  | Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 1431435.7   | 1431435.7   | 100.0 |
| 9  | Аймгийн нийт ангилагдаагүй зардал                              | 1,161,217.5 | 1,099,159.9 | 94.6  |
| 10 | Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц                              | 484,100.3   | 484,100.3   | 100.0 |
| 11 | Тусгай сангуудын зарлага                                       | 1,370,671.0 | 375,352.5   | 27.4  |

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

| Өргөн хэрэглээний барааны нэр төрөл    |                                      | 2017<br>X- сар | 2017<br>XI- сар | <u>2017-XI</u><br>2017-<br>X/төгрөгөөр<br>/ |
|--|--------------------------------------|----------------|-----------------|---|
| <b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>                 |                                      |                |                 |   |
| <b>1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>            |                                      |                |                 |   |
|  | Гурил /савласан, кг/                 | 1 250          | 1 250           |   |
|  | Талх /орон нутгийн, ш/               | 1 100          | 1 100           |   |
|  | Нарийн боов /кг/                     | 2 500          | 2 500           |   |
|  | Будаа /кг/                           | 2 200          | 2 400           | +200  |
|  | Элсэн чихэр /кг/                     | 2 200          | 2 200           |   |
| <b>2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>       |                                      |                |                 |   |
|  | Хонины мах /кг/                      | 5 000          | 5 000           |   |
|  | Үхрийн мах /кг/                      | 5 500          | 5 500           |   |
|  | Адууны мах /кг/                      | 6 000          | 5 500           | -500  |
|  | Ямааны мах /кг/                      | 5 000          | 5 000           |   |
|  | Дотор мах, цувдай /цусгүй/           | 3 000          | 3 000           |   |
|  | Хиам /чанасан, кг/                   | 11 000         | 12 000          |   |
| <b>3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b> |                                      |                |                 |   |
|  | Сүү /задгай, л/                      | 800            | 1 000           | +200  |
|  | Сүү / савласан, л/                   | 2 600          | 2 600           |   |
|  | Тараг /задгай, л/                    | 1 200          | 1 200           |   |
|  | Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/ | 1 300          | 13 000          |   |
|  | Айраг /л/                            | 3 500          | 3 500           |   |
|  | Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/ | 4 500          | 4 500           |   |
|  | Өндөг /ш/                            | 300            | 320             | +20   |
| <b>4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>           |                                      |                |                 |   |
|  | Ургамлын тос /л/                     | 3 800          | 3 900           | +100  |
|  | Өөхөн тос /кг/                       | 1 800          | 1 800           |   |
|  | Шар тос /кг/                         | 11 000         | 11 000          |   |
|  | Масло /задгай, кг/                   | 4 500          | 5 000           | +500  |
| <b>5 ХҮНСНИЙ НОГОО</b>                 |                                      |                |                 |   |
|  | Төмс /кг/                            | 1 200          | 1 200           |   |
|  | Лууван /кг/                          | 1 500          | 1 500           |   |
|  | Манжин /кг/                          | 1 500          | 1 500           |   |
|  | Байцаа /кг/                          | 1 500          | 1 500           |   |
|  | Сонгино /кг/                         | 1 500          | 1 500           |   |
|  | Өргөст хэмх /шилтэй, дарсан/         | 4 500          | 4 500           |   |
|  | Алаг салат /шилтэй, Urbanek, 630gr/  | 2 800          | 2 800           |   |
| <b>7 ШАТАХУУН</b>                      |                                      |                |                 |   |
|  | Бензин А - 80                        | 1 480          | 1 480           |   |



|               |       |       |
|---------------|-------|-------|
| Бензин А - 92 | 1 630 | 1 630 |
| Дизелийн түлш | 1 720 | 1 720 |

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

#### **1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:**

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах зорилгоор Хилийн 0101 дүгээр анги, Улсын бүртгэлийн хэлтэс, Гаалийн газруудад сургалт зохион байгуулж, 84 албан хаагчийг хамруулснаас гадна Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтэс, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн сургалтыг 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтанд агентлаг, сумдын удирдлагууд болон нууцын асуудал хариуцсан болон нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнуудыг хамрууллаа.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний дагуу “Команд штабын дадлага, сургалт”-ыг 2017 оны 11 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Цэргийн штаб, аймаг дахь Тагнуулын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хилийн ангиуд, Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар, Шүүхийн шинжилгээний албаны хүч хэрэгслийг оролцуулан зохион байгуулж, Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг мөн сарын 30-ны өдөр зохион байгуулсан.

Хууль, эрх зүйн хэлтсийн өдөр арга хэмжээг Түшиг, Цагааннуур суманд зохион байгуулж, төр, төсвийн байгууллагуудын албан хаагч, иргэдийн төлөөлөл нийт 111 хүнд Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт сэдвүүдээр сургалт хийж, Түшиг сумын Засаг даргын 85 захирамж, Тамгын газрын даргын 28 тушаал, Цагааннуур сумын Засаг даргын 83 захирамж, Тамгын газрын даргын 76 тушаалыг тус тус хянаж ажилласан.

Аймгийн хэмжээнд 2017 оны 11 дүгээр сард 615 холбогдогчтой, 1612.2 сая төгрөгийн хохиролтой, 624 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38 хэргээр буюу 5.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сумын 1, 2, 6, 7, 8-р баг, Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Баянгол, Сайхан, Орхон сум, Бугант тосгонд 3.3-84.6 хувиар, Хүдэр, Хушаат сумдад 2-3.1 дахин өсч, Сүхбаатар сумын 3, 4, 5-р баг, Шаамар /Дулаанхан тосгон/, Жавхлант, Цагааннуур, Түшиг, Сант, Баруунбүрэн сумдад 10-57.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 11 дүгээр сард 240 төрөлт, 65 гэрлэлт, 10 гэрлэлт цуцлалт, 55 нас баралт бүртгэгдэж, 600 иргэнд цахим үнэмлэх, 62 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх 6273 ширхгийг тус тус олгож, аймаг, хотруу шилжин явсан 208, шилжин ирсэн 235, сум дүүрэгт шилжин ирсэн 71, сум дүүрэгт шилжин явсан 71, баг хооронд шилжин ирсэн 215, баг хооронд шилжин явсан 212 шилжилт хөдөлгөөн тус тус бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 396 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 588 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамжийн 138555 төгрөг, үйлчилгээний хураамжийн 8373550 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварт 79138000 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

#### **2.Архивын талаар**

Тайлант хугацаанд Хүдэр сумын хорооллын доторх 0,8, 1,66 км авто замын ажлын гүйцэтгэл, 9,8 км хайрган хучилттай замын засварын ажлын гүйцэтгэл, хорооллын замуудад шар усны үерийн хоолой тавьсан ажлын зураг төслийн баримт бичгүүдийг хүлээн авч бүртгэл, акт үйлдэж хөмрөгт байрлуулсан. Мөн “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын баримтад иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийж 1959-2002

оны 190 хадгаламжийн нэгжийн дансны шинэчилсэн бүртгэлийг гаргаж БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгож, 1959-2002 оны 84 хадгаламжийн нэгжид ЭШТБ-ын ажлыг архив зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

2017 оны БНШАЗК-ын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2017 онд нягтлан шалгалт хийгдсэн хөмрөгүүдийн дансны шинэчилсэн бүртгэлүүд, шинээр хөмрөг үүсгэсэн “Цант-Орхон” ХХК, 2, 5-р сургуулийн байнга хадгалах хн-ний бүртгэл мөн Сайхан сумын Номгон тосгоны 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, ДЗОУБ-ын байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, аймгийн Аудитын газар, Шаамар сумын ЕБС, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Сант сумын ЗДТГ-ын хадгалах хугацаа дууссан баримтын устгах жагсаалт /нийт 15 асуудал/-ыг хурлаар хэлэлцэж, 14 асуудлыг баталгаажуулсан.

Архивын гэрээт ажилтнуудын 11-р сард хийсэн ажлын мэдээг нэгтгэж Архивын ерэнхий газарт хүргүүлж, Сүхбаатар сумын 2 дугаар сургуулийн 1986-2004 оны 19 хадгаламжийн нэгжийн баримтын мэдээллийг төрийн архивын АМС программд шивэх ажлыг гүйцэтгэлээ.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:**

2017-2018 оны хичээлийн жилд Боловсрол, соёл, урлагийн газрын ажлын хэсэг тэргүүлэх мэргэжлийн зэрэг авах, сунгахыг хүссэн 33 багшийн материалыг хүлээн авч 26 багшид тэргүүлэх мэргэжлийн зэрэг, кабинетийн гэрчилгээг шаардлага хангасан 72 кабинетад олгосон. 2017-2018 оны шилдэг илтгэл хэлэлцүүлэх эрдэм шинжилгээний бага хурал, шилдэг илтгэл шалгаруулах уралдааныг зохион байгуулж эрдэм шинжилгээний бага хурал, шилдэг илтгэлийн уралдаанд 5 бүсээс шалгарсан 5 илтгэлийг хэлэлцүүлэн Сайхан сумын ЕБС-ийн багш Д.Цэвээнсүрэн, М.Энхтуул, Ц.Хонгорзул, М.Алтаннамар нарын “Ухаалаг хэрэглээ-Ухаалаг зорилго” илтгэл шалгарч, 3 дугаар шатны улсын уралдаанд оролцох эрхтэй болсон.

Цагааннуур сумын Улсын тэргүүний Нарлаг цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсролын 65 удирдах ажилтан, арга зүйч нарт зориулж үзүүлэх сургалтыг зохион байгууллаа. Мөн ОХУ-ын Буриад улсын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд цэцэрлэгийн эрхлэгч, нярав, тогооч нийт 54 хүнд “Хүүхдийг эрүүл хоол хүнсээр хангах нь” сургалтыг 11-р сарын 13-нд байгуулсан.

Монголын оюутны холбооноос аймгийн төвийн сургуулиудын 11-12-р ангийн 362 сурагчдад “Мэргэжлийн чиг баримжаа олгох цогц сургалт”-д зохион байгуулж, мэргэжлээ хэрхэн зөв сонгох, ажлын байрны төсөөлөлтэй болгоход дэмжлэг үзүүлсэн.

“Тэргүүлэх зэрэг” олгох нийтлэг шалгуур үзүүлэлтийн нэг болох “Судалгаа хийх, гадаад хэл, мэдээлэл технологийн зохиох түвшний мэдлэг, чадвартай байх” шалгуурын дагуу зэрэг гориллогч багш нараас авах шалгалтын даалгаврыг Google маягтан дээр боловсруулан 30 нд шалгалтыг авлаа.Шалгалтанд СӨБ-ын 7, ЕБС-ийн 12 багш, сургалтын менежер 5, нийт 24 багш, удирдах ажилтан мэдээллийн технологийн шалгалтыг амжилттай өгөв.

2017 оны 11-р сарын 8-10- ны өдрүүдэд Боловсролын Үнэлгээний Төвтэй хамтран хөтөлбөрт суурилсан эцсийн үнэлгээний даалгавар боловсруулах арга зүйн талаар мэдлэг, ойлголтыг эзэмшүүлэх зорилготой“ Хөтөлбөрт суурилсан үнэлгээний даалгавар боловсруулах арга зүй” сургалтыг ЕБ-ын ахлах ангийн сургалтын менежер, математикийн багш, байгалийн ухааны багш, “СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр, үнэлгээ” сэдэвт сургалтыг СӨБ-ын багш, арга зүйч, эрхлэгч нийт 195 хүнийг оролцуулан зохион байгууллаа.

2017-2018 оны хичээлийн жилд Мандал сумын Билиг ДБ сургуулиас I-XII ангид математикийн хичээлээр гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулахаар ирүүлсэн багш нарын боловсруулсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үзүүлэн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, гарын авлагын жагсаалт,

багшийн ур чадвар / математикийн багш В.Болормаа, Р.Цолмон нар мэргэжлийн “Тэргүүлэх” зэрэгтэй /зэргийг судалж үзэн БСШУ ны сайдын 2002 оны 333 тоот тушаалын 2.1-д заасан шаардлагыг хангасан тул уг сургалтыг зохион байгуулах боломжтой гэж дүгнэлтийг гаргалаа.

Аймгийн 35 ЕБС-ийн БДБ 1-19 статистик мэдээг боловсролын салбарын мэдээллийн системээр авч тайлан мэдээг хянаж яаманд 2017-11-06 нд илгээсэн. ЭМГ-аас 2017.10-30-ны өдөр зохион байгуулсан “Салхин цэцэг” өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад Сүхбаатар сумын 8 сургууль, 7 цэцэрлэгийн эмч болон нийгмийн ажилтныг хамруулж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг бүх сургууль, цэцэрлэгийн цахим хаягаар хүргүүлэн, зөвлөн тусалж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа эрчимжүүлэх үүрэг даалгавар өглөө.

БОМСТ-оос зохион байгуулсан олон улсын “Эко сургууль” хөтөлбөрийн 3-р шатны сургалтыг Сайхан сумын Хөтөл ЕБС дээр 2017.10.25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Сүхбаатар сумын 1, 2, 3-р сургууль, Шаамар, Ерөө, Сайхан сумын Хөтөл ЕБС-иудын удирдлага, багш, сурагч болон БСУГ-ын мэргэжилтэн Л. Наранцэцэг нийт 60 хүн оролцож, 2 дахь шатны сургалтаар өгөгдсөн даалгаврын дагуу хийсэн ажлаа тайлагнан, зөвлөгөө авлаа.

2017-2018 оны хичээлийн жилд ажиллаж буй бага ангийн багш нарын судалгааг нэгтгэн дүгнэлт хийлээ. Энэ хичээлийн жилд ЕБС-ийн бага ангийн нийт 365 бүлэгт 10208 сурагч суралцаж, 358 бага ангийн багш ажиллаж байна. Эдгээр багш нарын 6 багш нь давхар анги даан ажилладаг бөгөөд төчнөөн багш дутагдалтай байгааг харуулж байгаа юм. Энэ жил бага ангийн сурагчдын тоо өмнөх оныхоос 477-оор нэмэгдсэн тул ойролцоогоор 20-оод бүлэгт шинээр багш шаардлагатай болж 21 багш шинээр ажилд орсон байна. Орон нутаг болгонд бага ангийн багшийн хэрэгцээ үүссэнтэй холбоотойгоор багшийн хүрэлцээ хангамж нилээд дутагдалтай байсаар байна. Багш нарын мэргэжлийн зэргийн үзүүлэлтийг харвал өмнөх оныхоос зөвлөх мэргэжлийн зэрэгтэй багш 2-оор, тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш 13-аар нэмэгдэж мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь 46,3%-тай байна.

2017 оны жил дуусах хүртлэх ХБГ-ээр манай газар нь тодорхой хэмжээний зардлуудад өглөг үүсэх магадлалтай байгаа бөгөөд зарим зардлыг бүлэг хооронд шилжүүлэн өглөгийг барагдуулах боломжтой байгаа бол тээвэр шатахуун, дотоод албан томилолт, цалин, ажил олгогчоос төлөх НДШ, төсөв нь 2016 оны төсвөөс буурч батлагдаж ирсэн зэргээс шалтгаалан байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч тээвэр шатахуун, дотоод албан томилолтын зардалд их хэмжээний өглөг үүсээд байна. Иймд дутагдаж буй зардлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулж дутагдаж байгаа зардлыг нэмж тодотголоор шийдүүлээ.

“Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв” сэдэвт судалгааг 25 байгууллагаас авч, нэгтгэн БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газарт хүргүүлсэн.

## **2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

2017 оны 10-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 895 байсан бол 302 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 258 ажлын байранд 216 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 151 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 830 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 11 сарын байдлаар 28781 иргэнд 9,033,343,623 төгрөгийг олгоод байна.

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар сумын МСҮТ, Шаамар МСҮТ, Голомт банк, Сэлэнгэ аймаг дахь үсчин, гоо сайханчдын холбоотой хамтран “Хөдөлмөрийн өдөрлөг”-ийг 11-р сарын 9-ний өдөр аймгийн Биеийн тамир спортын ордонд зохион байгуулж, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон МСҮТ-үүдийн суралцагчдын үзэсгэлэн худалдаа, үсчин гоо сайханчдын ур чадварын уралдаан, хөгжөөн цэгээнт “АХА” тэмцээн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

2017 онд хэрэгжүүлсэн “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдсан залуу малчин өрхүүдийн туршлага солилцох уулзалт зөвлөгөөнийг зохион зохион байгуулж, Баруунбүрэн, Орхон, Сайхан, Хүдэр, Ерөө, Зүүнбүрэн Жавхлант сумд Номгон тосгоны малчид оролцож, сүү цагаан идээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн ХАБЭА-н дэд хөтөлбөрийн хэрэгжилт цаашдын зорилтын талаар сургалт хэлэлцүүлэгийг зохион байгуулж, ХАБЭА-н зөвлөлийн дарга, Хөдөлмөрийн мэргэжилтэн, ҮЭХолбоо, ажил олгогчдын төлөөлөл зэрэг 105 хүн оролцлоо. Мөн “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага 2017” болзолт уралдаанд шалгарсан Том үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагаас Сайхан сумын Хөтөлийн цемент шохой ХК, дунд ангилалд Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ, жижиг ангилалд Мандал сумын Зүүнхараа ОНӨААТҮГ, ХАБЭА-н шилдэг ажилтан шалгаруулах уралдаанд Болдтөмөр Ерөө гол ХХК-ны ХАБЭА-н ажилтан Г.Содгэрэл тэргүүн байр, Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ-ын мэргэжилтэн У.Цэцгээ дэд байранд тус тус шалгарсныг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулан ажиллалаа.

### **3.Эрүүл мэндийн талаар**

Аймгийн ИТХТ-ийн 55-р тогтоол “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын санаачлагаар Хушаат сумын 15-аас дээш насны иргэдэд “Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг оношилгоо”-г зохион байгууллаа. Үзлэг оношлогоонд нарийн мэргэжлийн эмч зүрх судас, зүрхний ЭКГ, дотор, мэс засал, эрэгтэйчүүд, гэмтэл, хавдар, урологи, мэдрэл, сэтгэц, дотор эрхтний ЭХО, эмэгтэйчүүдийн үзлэг-ЭХО, уушигны эмгэг, нүд, чих хамар хоолойн эмч нарын үзлэг, зөөврийн дижитал рентген аппарат болон лабораторийн оношилгоо шинжилгээ, шүд, сэтгэц, Хүүхдийн эмч нарын үзлэг хийгдэж нийт давхардсан тоогоор 1020 хүнийг үзлэгт хамрууллаа. Мөн 2017 оны төлөвлөгөөт бус шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээг Орхонтуул, Хүдэр сумын эрүүл мэндийн төвүүдэд хийж хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, заавал мөрдөх стандартын хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгөх, санал дүгнэлт гаргах замаар аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 9 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллалаа. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дутагдалыг эрүүл мэндийн төвүүд болон сумдын Засаг дарга нарт нь зөвлөмж хэлбэрээр хүргүүлэн тодорхой хугацаанд зөрчлийг арилгуулах албан даалгавар өгөн ажиллаж байна. Дархлаажуулалтын 10 хоногоор сахуу татрангийн вакциныг 7, 15 настай 3197 хүүхдэд, 15 настай 1163 хүүхдэд улаанбурхны вакциныг хийж дархлаажуулсан. Улирлын томуугийн вакциныг жирэмсэн, өндөр настай, эрсдэлт бүлгийн 2300 иргэнд хийсэн байна.

### **4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийн дунд анхан шатны сургалтыг зохион байгуулж, 6 сумын 14 иргэн хамрагдаж, хүүхэд харах үйлчилгээ эрхлэх гэрчилгээ олголоо.

Сайхан, Орхонтуул, Сант, Түшиг сумдын хамтарсан баг, Хүүхдийн төлөө зөвлөлийн ажил байдалтай танилцаж зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, Дулаанхан тосгоны Хамтарсан багаас архины хамааралтай гэр бүлийг архинаас гаргах эмчилгээнд хамруулж тэдний гэр бүлд хүүхэд хамгааллын зардлаас 100.000 төгрөгийн тусламж үзүүлж хамтран ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг зохион байгуулж 34 хүүхдийг тодорхойлов.

Залуучуудын төвийн бүсийн чуулга уулзалт Мандал суманд “Эрхээ идэвхжүүлэе-Залуучуудын оролцоо” уриан дор зохион байгуулагдлаа.Чуулганд 100 гаруй залуучууд оролцон цаашид хамтран хийх ажил, төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийн талаар ярилцаж, санал бодлоо солилцлоо.

Чуулганд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж “Хувь хүний хөгжил” сэдвээр, Залуучуудын хөгжлийн бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Мандуул “Залуучуудын Хөгжлийг Дэмжих тухай” хуулийн танилцуулга хийж, тус газартай хамтран ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн оюутан залуусын дуу хоолой, идэвх санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих, орон нутгийн хөгжилд оюутан залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор их дээд сургуулиудад суралцаж буй Сэлэнгэ аймгийн харъяат оюутан залуучуудын дунд “Манлайлагч оюутан” илтгэлийн тэмцээнийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Сэлэнгэлэг оюутан” клубтэй хамтран зохион байгууллаа. Тэмцээний 1 дүгээр шатны шалгаруулалт “Сэлэнгэ нутгийн хөгжилд миний оролцоо”, “Оюутны хөгжилд орон нутгийн дэмжлэг”, “Хэрвээ надад боломж олговол...” сэдвийн хүрээнд цахимаар явагдаж, шалгарсан 20 илтгэгч 2 дугаар шатанд оролцон үүнээс 5 илтгэгчийг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийллийг тэг болгоё” сарын аяныг зохион байгууллаа. Аянд 17 сумын төрийн болон төрийн бус байгууллага оролцож, шинээр батлагдсан хуулийг сурталчлах, “Эцэг эхийн зөвлөл”-тэй болгох ажлыг зохион байгуулж ажиллав. Мөн аяны хүрээнд аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Эрүүл мэндийн газартай хамтран Сүхбаатар суманд согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудаар хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх зорилгоор оройн 21:00-00:00 цагт хүртэл хяналт үзлэг хийж ажиллалаа.

Хүүхдийн хүмүүжил, төлөвшилд гэр бүлийн суурь хүмүүжил, эцэг, эхийн үлгэр дууриалал, болзошгүй эрсдлээс хүүхдээ хамгаалах чадамжийг дээшлүүлэх зорилгоор “Эцэг эхийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан. Зөвлөгөөнийг аймгийн Цагдаагийн газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран 17 сумын Ерөнхий боловсролын 35 сургууль бүрээс нийгмийн ажилтан, 4 эцэг эхийн төлөөлөл, нийт 200 гаруй хүн оролцуулсан. Зөвлөгөөнийг зохион байгуулснаар Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эхийн зөвлөлийн ажлыг идэвхжүүлэх, хамтран ажиллах, байнгын эргэх холбоотой байх, эцэг, эх, хүүхдэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүүхэд хүмүүжүүлэх шинэ арга барилыг эзэмших, үр хүүхдээ хайрлан, өсгөж хүмүүжлэх хариуцлагыг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил боллоо.

Мөн гэр бүлийн үнэ цэнэ, хүүхдийн хүмүүжил, эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог сайжруулах үүднээс “Эцэг эх-хүүхдийн хүмүүжил” сэдэвт сургалтыг Түшиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 135 эцэг эх, багш нарт зохион байгууллаа.

Хүүхэд харах үйлчилгээний 10 дугаар сарын бүртгэл мэдээгээр нийт 8 сумын 12 төвд, 140 хүүхэд бүртгэгдэн хамрагдаж байна.

## **5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар**

2017 оны 11-р сарын байдлаар 23,88 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 11-р сарын 23-ны байдлаар өссөн дүнгээр 21,16 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 97,0 хувийн биелэлтэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 15858 тэтгэвэр авагчдад 45495.05 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 5910 хүнд 1983.00 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 301 хүнд 910.42 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 491 хүнд 653.62 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 3782.66 сая төгрөгийн зардлыг тус тус олгожээ. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 11 сард 70 иргэд, даатгуулагчид

гарган түргэн шуурхай үйлчиллээ. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2017 оны 11-р сард 426 хүнээс, 21 хүнийг цуцалж, 62 хүн шинээр тогтоолгож, 343 хүн актаа сунгуулсан.

Тайлант сард Сайхан сумын эрүүл мэнд, нийгмийн даатгалын тасгаас нийт 97 аж ахуй нэгж байгууллага шалгалтанд орохоос 64 аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн баримт, хүн амын орлогын албан татварын тайлан, шимтгэлийн ногдуулалт төлөлтийг нийгмийн даатгалын мэдээллийн баазтай тулган шалгаж хамрагдалт 65,9 хувьтай байна. Үүнээс 43 аж ахуй нэгж байгууллага төлбөр зөрчил гаргаагүй тул танилцуулга хуудас бичсэн. Мөн шимтгэлийн өртэй болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа хугацаандаа тайлагнадаггүй нийт 5903427,7 мянган төгрөгийн өртэй 36 аж ахуй нэгжүүдэд улсын байцаагчийн албан шаардлага өгч ажиллалаа. Шалгалтаар аж ахуй нэгж байгууллага нь даатгуулагчийн цалин ба түүнтэй адилтгах орлогыг орхигдуулсан, шимтгэлийн авлагыг хугацаандаа төлөөгүй, санхүүгийн баримтыг боловсруулаагүй зэрэг зөрчил илэрч, Үүнд: 13 аж ахуй нэгжид 18468,2 мянган төгрөгийн акт алданги бичсэн. Мөн даатгуулагчийн цалинг буруу тайлагнасан 1 аж ахуй нэгжид Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.4 дэх заалтын дагуу 10,0 мянган төгрөгийн торгууль тавьж ажиллалаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2015 онд 6108657,1 мянган төгрөг, 2016 онд 5895177,4 мянган төгрөг, 2017 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 6326433,5 мянган төгрөг болж урьд оныхоос 107,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 3 аж ахуйн нэгж, байгууллагын 3686653 төгрөгийн төлбөр барагдаж урамшууллын материалыг ЭМНДЕГ-т хүргүүлээ.

### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, байгаль орчин, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд:**

#### **1.Хүнс, хөдөө аж ахуйн талаар**

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран “Сэлэнгэ аймгийн махны нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудын уулзалт”-нд Мандал, Зүүнбүрэн, Ерөө, Цагааннуур, Алтанбулаг, Сүхбаатар, Хушаат сумдын махны салбарын 23 төлөөллийг оролцуулан зохион байгууллаа. Энэхүү уулзалтаас мал нядлах, мах боловсруулах, ангилж савлах, үйлдвэрт тавигдах олон улсын стандартууд болон импортлогч орнуудын шаардлагууд, Сэлэнгэ аймгийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар санал бодлоо солилцсон ажил хэрэгч уулзалт болж, аймгийн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААҮҮГ-ын мал нядалгааны цех, “Гацуурт” ХХК-ний махны үйлдвэр, “Цаст булган хайрхан”ХХК-ны ангилан савлах цехүүдийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөхүүд газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Энэ жил 141.2 мянган мал байнгын, 778.8 мянган мал нэмэгдэл тэжээлтэй өвөлжих бөгөөд эдгээрт шаардагдах тэжээлийг бэлэн байгаа тэжээлтэй харьцуулахад тэжээлийн хангамж 98 хувьтай байна.

Малын хашаа, байр засах, уст цэгийг лайдах, засварлах, өтөг бууц, түлээ түлш бэлтгэх ажлыг малчид, мал бүхий аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн хүчээр гүйцэтгэж, нийт малчин, мал бүхий өрхийн бэлтгэл хангалт 89,7 хувьтай байгаа боловч аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт хангалтгүй байгаагаас аймгийн нэгдсэн дүнгээр 86.9 хувиар өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангасан дүнтэй байна.

“Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хууль, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2017 оны А/215 тоот захирамжаар ангилалт хийх мэргэжилтэн, ангилал малын тоог хавсралтаар тогтоож сумдад хүргүүлэв. Мөн ХХААГ-ын даргын 2017 оны 05 сарын 15-ны өдрийн 11 тоот тушаалаар үзлэг, ангтлалтын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 5 хүний

бүрэлдхүүнтэйгээр байгуулан ажилласан. Сумдын Засаг даргын захирамжаар мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын төлөөлөлөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, туслах ажилтныг тусгайлан томилж ажиллууллаа. Мал ангилалтын ажилд аймгийн дүнгээр 21 мэргэжилтэн 34 туслах ажилчин, бүгд 55 хүн ажилласан байна.

Энэ онд 54,4 мянган бог мал хамрагдсанаас 48172 толгой хонь, 6316 толгой ямаанд үзлэг, ангилалт хийв. Үзлэг ангилалтанд хамрагдсан нийт эм хонины 127 хувь буюу 45800 толгой, хуцны 65.8 хувь буюу 2371 толгой, эм ямааны 2 хувь буюу 5109 толгой, ухны 50 хувь буюу 1207 толгой ухна хамрагдлаа. Дээрх үзлэг ангилалтанд хамрагдсан хониноос Ерөө суманд үржүүлж байгаа Ерөө үүлдрийн 4011 хонь, Орхон, Сайхан, Мандал суманд үржүүлж буй Орхон үүлдрийн 7004 хонь, Цагааннуур суманд үржүүлж буй Хангай үүлдрийн 4218, Баяд үүлдрийн цөм сүргийн 2990 толгой хонь нийт 18000 толгой нарийн, нарийвтар ноост хонь болон баяд үүлдрийн хонь ангилалтанд хамрагдав.

Өвөлжилтийн бэлтгэл ажил цаг үеийн ажлын талаар Хүдэр, Ерөө, Жавхлан, Хушаат, Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн, Шаамар, Орхонтуул, Баруунбүрэн, Сайхан, Орхон, Сант зэрэг сумдад ажилласан. Аймгийн отор нүүдлийн судалгаа сумдаар нарийвчлан авч гаргасан. Гадны аймгаас отор нүүдлээр манай аймгийн 11 суманд Төв аймаг, Архангай, Дархан-Уул, Булган, Орхон, Говьсүмбэр, Хэнтий зэрэг аймгуудаас 21 малчны бод 2517, бог 12759 нийт 15310 мал отроор ирсэн байна. Манай аймгийн 53 малчин гадны 10 аймагт нийт 14282 мал отроор өвөлжихөөр гарсан мэдээтэй байна.

Олон улсын худалдааны Хорио цээрт “А” зэрэглэлийн малын гоц халдварт шүлхий өвчний сэжиг Минжийн хангайн 7-р багийн нутаг 42 тоотод оршин суух Лувсанбалдан овогтой Даваагийн /95003611/ үхэрт 2017 авсан дээжинд хийсэн Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2017 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 15 цагт 17-2433 тоот шинжилгээний дүнгээр гоц халдварт шүлхий өвчний “О” хэвшил болох нь батлагдаж МХГ-ын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Х.Бейбетийн дүгнэлтийг үндэслэн сумын Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 15 цаг 35 минутанд 407 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоон хүч нэмэгдүүлэн байнгын 3 пост, хөдөлгөөнт 13 пост гарган хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зогсоож ажиллаж байна. Сумын хэмжээнд шүлхий өвчинд мэдрэмтгийн 1571 өрхийн 33409 үхэр, 1307 гахай, 54 тэмээ, 36436 хонь, 32118 ямаа байгаа бөгөөд үүнээс голомтын болон сэжигтэй бүсэд 18793 үхэр, 651 гахай, 70 ямаа байна. Гоц халдварт шүлхий өвчин гарсантай оношлогдсонтой холбогдуулан дархлаажуулалтын 13 хэсэг малын эмч, ачааны 4 машин, хяналтын 2, халдваргүйжүүлэлтийн 2 машин, нядлагч-2, ачигч нийт 31 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

## **2. Байгаль орчны талаар:**

2017 оны 11-р дүгээр сарын хоёрдугаар 10 хоногийн байдлаар энэ сарын 6, 9, 12, 16-нд бүх сумдын нутгаар, 5, 11-нд нутгийн хойд хэсгээр, 13-нд нутгийн өмнөд хэсгээр 0,0-4,0 мм цас орж, ихэнх хугацаанд салхи баруун хойноос болон баруунаас 5-10 м/сек, Орхонтуул, Орхон, Баруунбүрэн, Хүдэр, сумдын нутгаар цасны зузаан 4-10 см, бусад сумдын нутгаар цасны зузаан 1-3 см байна.

Агаарын температур 1-р арав хоногт шөнөдөө 13-18 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан, 2-р арав хоногийн эхээр хүйтэрч шөнөдөө 21-26 градус, өдөртөө 10-15 градус хүйтэн, бусад хугацаанд шөнөдөө 13-18 градус, өдөртөө 2-7 градус хүйтэн байлаа.

Сүхбаатар суманд агаарын бохирдол, гадаргын усны гидрохимийн шинжилгээ, цацрагийн түвшин нь стандарт хэмжээнээс хэтрээгүй байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж  $0.015 \text{ мг/м}^3$ , хамгийн их агууламж  $0,024 \text{ мг/м}^3$ , хүхэрлэг хийн дундаж агууламж  $0,003 \text{ мг/м}^3$ , хамгийн их агууламж  $0,006 \text{ мг/м}^3$ , агаарын тоомсонцорын дундаж агууламж  $0,036 \text{ мг/м}^3$ , хамгийн их агууламж  $0,066 \text{ мг/м}^3$  байв.

2017 оны 11-р сарын байдлаар Баянгол сумын “Бороогоулд” ХХК 2.7 га талбайд биологийн нөхөн сэргээлт, “Тод-Ундарга” ХХК 10 га талбайд техникийн, 3,1 га талбайд биологийн нөхөн сэргээлт, Ерөө сумын “Болд төмөр Ерөө гол” ХХК 3.6 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт, “Инфинити спейс” ХХК 1.1 га талбайд техникийн, “Бүүргэнт” ХХК 16.09 га талбайд техникийн, “Ди Зэт энд Ай” ХХК 2.1 га талбайд техникийн болон биологийн, “Бугант нандин” ХХК 2.25 га талбайд техникийн болон биологийн, “Толгойтын гол” ХХК 1 га талбайд техникийн, 0.05 га талбайд биологийн нөхөн сэргээлт, “Ганбат тулга” ХХК 22 га талбайд техникийн, Хүдэр сумын “Уулс ноён” ХХК 7,25 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил тус тус хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 05 тоот тушаалын дагуу аймгийн Засаг даргын 2017 оны А/430 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Ди Зэт энд Ай” ХХК, “Бороогоулд” ХХК, “Ганбат тулга” ХХК, “Уулс ноён” ХХК, “Болд төмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спейс” ХХК, “Бүүргэнт” ХХК, “Цемент Шохой” ХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг шалгаж, ажлын хэсгийн дүгнэлт гаргаж ажиллалаа.

Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө” боловсруулахад орон нутгаас санал авах хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр арга хэмжээ тус бүр дээр Хүдэр, Ерөө, Баруунбүрэн, Сант, Хушаат, Орхон, Орхонтуул зэрэг сумдын байгаль орчны хяналтын Улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдээс санал авч нэгтгэн төслийн Зөвлөх багт хүргүүллээ.

2017 оны А/20 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг Алтанбулаг, Мандал, Орхонтуул, Ерөө сумдын 5 булаг, шанд тохижуулах ажил, Жавхлант сумын цөлжилт, элсний нүүдлээс хамгаалсан хамгаалалтын зурвас байгуулах зэрэг ажлуудын гүйцэтгэлийг шалгаж хүлээн авлаа.

“Ойн нөхөрлөлүүдийн өнөөгийн байдал цаашид авах арга хэмжээ” сургалтыг одоогоор Хүдэр, Ерөө, Баруунбүрэн, Цагааннуур сумдуудад зохион байгуулаад байна.

### **3.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системээр өмч хөрөнгийн мэдээллийг шивэхтэй холбогдуулан сумдын нягтлан бодогч нарт сургалт хийж, 2017 оны жилийн эцсийн тайлангийн мэдээллийг өнөөдрийн байдлаар 70 хувь шивж оруулаад байна.

2017 оны 11-р сард аймгийн ИТХ-аар төсвийн тодотгол хийгдсэнтэй холбогдуулан шинээр 5 төсөл арга хэмжээ, Улсын төсвөөс 2 ажлын эрх шилжин ирж, нийт 7 тендер зарлагдсан. Үүнээс Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хөдөө ажиллах автомашин авах, аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт тоног төхөөрөмж авах, Сүхбаатар сумын 2, 4 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах, аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их засварын ажил, Сумдын 40 байгаль хамгаалагч нарт өвөл, зуны иж бүрэн нормын хувцас, гутал авах, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шаардлагатай тоног төхөөрөмж авах, Байгаль хамгаалагч нарт шаардлагатай тоног төхөөрөмж авах, Мандал, Ерөө сумын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын цахилгаан хангамж зэрэг 8 төсөл арга хэмжээ тендэр хүлээн авах шатандаа байна. Орхон Сэлэнгийн бэлчирт үерийн хамгаалалтын далан барих /120 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий/ ажлын төсөв ирээгүй тул тендер зарлагдаагүй 1 төсөл арга хэмжээ байна.

Хүдэр сумын нутаг дэвсгэрт баригдаж буй сумын төвийн бетон хучилттай авто замын ажилд 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр захиалагчийн хяналтыг хийж техникийн комисс ажилласан. Ажлын гүйцэтгэлд замын ус зайлуулах яндан хоолойн гадуур бетон цутгалт хийснийг дахин нэмж бетондох, замын далангийн том чулууг түүж цэвэрлэх, замын хашлага руу асгасан далангийн шороог зөөж зайлуулах зэрэг



үүрэг даалгавар өгч магадлашгүй ажлын зардлаар хийгдэх ажлын хурлын тэмдэглэл, хүлээлцсэн актыг бичиж баталгаажууллаа. Мөн тус сумын нутаг дэвсгэрт баригдаж буй сумын төвийн бетон хучилттай 0.8 км авто замын ажил, Хүдэр сумын ус зайлуулах хоолойн ажил, Хайрган хучилттай авто замын ажил, Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажилд улсын комисс ажиллалаа.

Мандал сумын GPS/GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тоон мэдээлэл дамжуулах сүлжээ /VPN/ болон Router, дотоод сүлжээний төхөөрөмж /Switch/-үүд тог баригч /UPS/-т холбон, ил гарсан дотоод сүлжээний кабелиудыг бүрэн далдалалсан. ГХГЗЗГ-т кадартыг хэлтсээс тус станцын бодолтыг хийж гүйцэтгэж дуусаагүй байна. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт суурилуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай станц, түүний удирдлагын системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, мэдээлэл дамжуулах кадастрын хэмжилтэд ашиглаж байна. Мөн GPS/GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын гэмтэл, холболтын алдааг өдөрт 1-2 удаа шалгаж байна.

Алтанбулагийн Худалдааны чөлөөт бүсийн гадна бохир усны 25 км шугам, барилга байгууламжийн ажлын явцад хяналт хийж маш ноцтой зөрчил доголдлыг илрүүлж захиалагч болох АХЧБ-ийн захирагчийн албанд албан тоот болон фото зургаар баталгаажуулсан хавсралтыг хүргүүлэв. Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт” төсөлтэй хамтран хэрэгжүүлж буй “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлын хүрээнд хийгдсэн /16 суманд 68 цэг байгуулан/ тайланг дээд газарт хүргүүллээ.

### Зургаа.Сум орон нутгийн талаар:

#### Алтанбулаг сум:

Сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/64 тоот захирамжийн дагуу бод малд үзлэг ангилалт хийх, ашиг шимийн гарцын тодорхойлж, цэвэр эрлийз үхрийн тооллогыг явуулсан.

Энэ сарын 26-нд мал бүхий өрхүүдээр өвөлжилтийн бэлтгэл ажил болон мал эмнэлгийн үйлчилгээ, өрхийн малын эрүүл мэнд дэвтэр зэрэгт хяналт тавин ажиллалаа.

Сумын Байгаль орчны тасаг, цагдаагийн тасаг, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдтэй хамтран нийт 18 удаа эргүүл шалгалт хийж Ойи ооооае аи еи и Ангийн ооооае хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн. Мөн “Оёө еа<sup>а</sup> í ä° ð Í é” АААОИ í ü оёñü í ð ñæéí ð° ð° í æ í ðóóеаёоааò 10 ää õí оёðóоёаò í æёí еüí àæü ä Öóää<sup>а</sup> í ä° ðò оёеёуä õüí àёò оääъж, Ааеääёü í ð-í ü ýàì , Ì ýðäýæёёéí õüí àёòüí àð°í оёе äçàð àеí æéí Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газруудын хамтарсан “Хяналт” нэгдсэн àðää õüí æуú ð° е° àё° æ°ò ø àеääёò еðæ Аí ÖÖÁàеöääã-, Ааеääёü оàì äààеää-, Ì ýðäýæёёéí àаеäóоёаäóäüí àе-еä ààðеí оóóä áí еí í ð° ð° ðàì оóääàð ø àеääёò оёеёсэн.

Алтанбулаг суманд Хүн амыг орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-д хамруулах ажлыг зохион байгуулан явууллаа. Сорил авах ажлыг 2017 оны 10 сарын 10-наас 11 сарын 10-ныг хүртэл хугацаанд “Бүгдээрээ сорилдоо Бүрэн хамрагдацгаая” уриан дор явуулж, Дамбо, Найрамдал цэцэрлэгийн багш ажилчид болон 3-5 насны хүүхдүүд, ЕБС-ийн багш ажилчид 9-11 нас, 6-8 настай сурагчид, “Алтанплаза” зочид буудлын ажилчид, Соёлын төв, сумын ЗДТГ, Орон нутгийг судлах музей, ЭМТ-ийн эмч ажилчид зэрэг нийт 682 иргэнийг хүн амын бие бялдарын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамруулсан. Сорилын дүнг [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) сайтанд байрлуулаа.

2017 оны 10-р сарын 27-ны өдөр төр, төсвийн байгууллага, ард иргэд, аж ахуйн нэгжийн дунд “Яг түүн шиг” караоке тэмцээнийг сумын СМТ-өөс зохион байгуулж, Дамбо цэцэрлэг 1-р байранд шалгарсан. Цэнгээнт бүжгийн “Гэгээн хүслэн-

2017” тэмцээнд 6-10-р ангийн 10 хамтлаг оролцож аваргуудаа шалгаруулж, НУЗАН-ийн нэрэмжит сарын аяны хүрээнд зохион байгуулсан “Уран жиргээчид” шүлгийн наадмын зохион байгуулж шилдгүүдээ тодруулсан.

Өсвөр үе, залуучуудыг эх оронч үзэлтэй, ёс суртахууны өндөр соёлтой, хөдөлмөрч, хууль ёс заншилаа эрхэмлэн дээдэлдэг, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Иргэний андгай өргөх ёслолын арга хэмжээг Засаг даргын тамгын газрын иргэний танхимд зохион байгууллаа. Монгол Улсын иргэний үнэмлэх батламжийн хамт гардан авлаа. Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл болсон 20 сурагч оролцлоо.

### **Ерөө сум:**

Сумын хэмжээнд арван нэгдүгээр сарыг “Бүтээмжийг дээшлүүлэх сар” болгон зарлаж, аяны хүрээнд төр төсвийн байгууллагад төрийн хөтөчийн ажил арга хэмжээг зохион байгууллаа. Төрийн хөтөчийн ажил үйлчилгээгээр нийт давхардсан тоогоор 2450 гаруй иргэд үйлчлүүлсэн бөгөөд албан хаагчдыг үйлчилгээнд санал асуулга авч иргэдэд чөлөөтэй, ээлжийн амралттай, ззэнгүй байгаа албыг түргэн шуурхай хариу өгч ажилласан.. Санал асуулгын дүнгээр хамгийн их иргэдэд үйлчилж сэтгэлд хүрсэн үйлчилгээ үзүүлсэн албан хаагчаар Татварын улсын байцаагч шалгарлаа.

Сумын Засаг даргын тамгын газраас санаачлан ахмад үе үеийн албан хаагчидтайгаа “ХИШИГ ӨДӨР” арга хэмжээг энэ сарын 20-нд амжилттай зохион байгуулж, Ерөө сум сангийн аж ахуй байх үед удирдагч асан Ж.Гэрэлчулуун, 2004-2009 онд сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгчөөр ажиллаж байсан С.Ганболд, ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан Б.Энхтуяа, Тавин багийн Засаг дарга асан А.Бадамгарав, Буурагчин багийн Засаг дарга асан Н.Бат-Эрдэнэ, ИТХ-ын дарга, Татварын улсын байцаагч асан Н.Дэлгэрцэцэг, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Т.Дэлгэрсайхан, Мал зүйч асан Р.Зоригт, Г.Пүрэвдорж, бичээч байсан Ж.Одтуяа, Хөдөө аж ахуйн тасгийн дарга асан Я.Баярсэд, Халамж үйлчилгээний мэргэжилтэн асан Д.Отгон, үйлчлэгч асан Ц.Олонсүрэн, тогоогч асан Д.Отгонбаяр, галч манаач асан Д.Цэдэнбал, Р.Нямдорж, нар урд өмнө хийж байсан албан тушаалаа хариуцан хийсэн. Өдрөөр ахмад албан хаагчдын Засаг даргын зөвлөл хуралдаж Ургацын баярын арга хэмжээний номинацийн эздийг шалгаруулсан.

Ахмад албан хаагчид 7 бүтээлч ажлын хүрээнд Ерөөчүүдээ манлайлж оролцохоор санал санаачлага гаргаж ажил үүргийг хуваарилснаа залуу албан хаагчдад танилцууллаа. Үүнд:

- Хоггүй Ерөө сум /ажлын хэсгийн ахлагч Байгаль орчны хяналтын улсын байцаагч асан Т.Дэлгэрсайхан/
- Ногоон сум болох /ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч асан Б.Нармандах/
- Гудамж төсөл /ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч асан Б.Нармандах/
- Шинэ төлөвлөгдсөн газарт хаус төсөл ЗДТГ-ын дарга асан Б.Энхтуяа
- Эрүүл Ерөөчүүд /Буурагчин багийн Засаг дарга Н.Бат-эрдэнэ/
- Зуун жилийн түүхэн товчоон /ИТХ-н дарга асан Ж.Гэрэлчулуун/
- Аж үйлдвэржсэн Ерөө сум /Хөдөө аж ахуйн тасгийн дарга асан Я.Баярсэд /

Зөрчлийн тухай хуулиар Худалдаа үйлчилгээ эрхэлчдэд сургалт зохион байгуулж, хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж иргэдийн дунд “Зөрчлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын зүйл заалтуудын талаар сургалт хийж, худалдаа үйлчилгээний газруудтай хийх “Хамтран ажиллах гэрээ”-г танилцуулж худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн санал бодлыг нь сонслоо. Сургалтын явцад худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар санал бодлоо солилцлоо.

Сумын Засаг даргын тамгын газраас санаачлан худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгжүүдтэй хамтран төр төсвийн байгууллага, өсвөр үе залуучуудын дунд архины хор

уршгийг сурталчлах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийгмийн хариуцлагыг сайжруулах үүднээс жилд 2 удаа нийтийг хамарсан урлаг спортын арга хэмжээг зохион байгууллахаар төлөвлөн 11 дүгээр сарын 5-ны өдөр “Спиртлэг биш Спортлог амьдаръя” уриан дор “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд төр төсвийн байгууллага, оюутан залуучуудын нийт 8 баг тамирчид оролцож хурд хүч, авъяас чадвараа сорилоо. Нийт оролцсон баг тамирчдаас эрэгтэй 1,2-р байр, эмэгтэй 1,2-р байрыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Сумын “Ургацын баяр-2017” арга хэмжээг зохион байгуулж, “Бид Ерөөгийн баялаг бүтээгчид” үзэсгэлэн худалдаа, баярын хурал, гар бөмбөгийн тэмцээн, Үндэсний бөхийн барилдаан, урлагийн тоглолт, хүлээн авалт, үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа.

2017 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр Ерөө сумын 1-р багийн малчин Б.Өлзийбаатар нь Мандал сумаас үхэр оруулж ирсэн мэдээллийн дагуу багийн Засаг дарга, ХАА-н тасгийн малын эмч, “Лха-Чинбу” ББН-ын малын их эмч, хэсгийн цагдаа, аймгийн мал эмнэлгийн Лабораторийн эрхлэгч, ийлдэс судлаач эмч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг газар дээр нь очиж үзлэг шинжилгээ хийж мэдүүлэг авсан. Үүний дагуу малыг тусгаарлаж, холбогдох шинжилгээг авсан бөгөөд шинж илрээгүй. Хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, сумын Засаг даргын захирамжаар түр хорио цээр тогтоон ажилласан. Мандал сумаас авчирсан хар халзан бухан бярууны арьс, толгой, шийрийг нүх ухан шатааж устгаж, ойр орчмын малчин өрхүүдэд шүлхий өвчний талаар мэдээлэл өгч, гарын авлага тараасан.

Байгаль орчны тухай хууль тогтоомжийн талаарх хяналт шалгалтыг хийж, дэрвэгэр жиргэрүүгийн хяналтыг сайжруулах ажлын хүрээнд 10-р сарын 23-аас 11-р сарын 22-ний өдрийг хүртэл 5 удаа Хонгор, буйлааст, Хөх чулуут, яргайт, Энх тал гэсэн газруудаар эргүүлд гарч ургамал түүж буй иргэдэд зөвшөөрөлтэй эсэхэд нь хяналт тавьж ажиллаа. Илэрсэн зөрчилгүй бөгөөд 11 сарын 16-ний өдрөөс хойш зөвшөөрөл авсан компанийн ажилчид болон иргэд ажиллаагүй болно.

Тайлант сард шинэ төрсөн 5, эцэг тогтоолгох 2, Шинээр гэр бүл болсон 2, гэр бүлээ цуцлуулсан 1, нас барсан 1, шилжин ирсэн 10, шилжин явсан 12 иргэнийг нотлох баримтыг үндэслэн бүртгэж иргэний гэр бүлийн бүртгэлийн мэдээллийн санд оруулсан. Мөн иргэний үнэмлэхээ шинээр 14, 25, 45 насны сунгалтаа хийлгэх 24, иргэний үнэмлэхээ дахин авах 4 иргэний хүсэлт материалыг хүлээн авч ИШБ-д бүртгэн материалыг аймгийн УБХ-т хүргүүлэн хэвлэгдэн гарсан 31 иргэний үнэмлэхийг ИУБ-21 маягт хөтлөн олголоо. Иргэний баримтын архивын лавлагаа гаргуулахаар хүсэлт гаргасан иргэдийн 6 гэрлэсэн эсэх, 2 гэрлэлтийн лавлагаа, 6 иргэний үнэмлэхний лавлагааг гаргуулан мөн төрсний гэрчилгээг дахин авах хүсэлтийн дагуу 3 гэрчилгээг гаргуулан, 2 иргэний гэрлэлтийн мэдээллийг санд оруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн хугацаанд газар болон үл хөдлөх эд хөрөнгөө өмчлөх хүсэлт гаргасан иргэдэд эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой хууль эрхзүйн зөвлөгөө өгч шинээр газар өмчлөх 4, хашаа байшингаа өмчлөх 2 иргэн, худалдах-худалдан авах гэрээний 4, өвлөх эрхийн гэрээний 2 материалыг хүлээн авч хувийн хэрэг нээн аймгийн ЭХЭБ-ийн тасагт хүлээлгэн өглөө хэвлэгдэн гарсан 4 иргэний газар өмчлөлийн гэрчилгээ 2 ҮХЭХ-ийн гэрчилгээг бүртгэл хөтлөн олгосон.

2017 оны 10-р сарын 23-аас 11-р сарын 12-ныг хүртэл үрэгжилсэн Экскаваторын опреторын сургалтыг “Замчин” сургалтын төвтэй хамтран нийт 21 ажилгүй ажил хайгч залуусыг үнэ төлбөргүй хамрууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2017 оны 11-р сарын 12, 13-ны өдрүүдэд “Бидний өдөр” үйл ажиллагааг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нийт 70 гаруй иргэн хүрэлцэн оролцож, урлаг, спортын арга хэмжээнд авъяас чадвар, авхаалж самбаагаа сорилоо. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах тухай” хууль, нийгмийн даатгалын сайн дурын даатгалын тухай хуулийг сурталчилж,

НӨАТУСистемийн тухай болон төлбөрийн баримтаа бүртгүүлэн хөнгөлөлтөд хамрагдах зааварчилгааг өгч хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэнд цахим хаяг нээж, урамшууллын системд нэвтрэх эрхийг нээн өгч, Ерөнхий боловсролын сургуулийн 26 багш, ажилчинд нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн сурталчилгааг хийсэн.

Эрүүл мэндийн төвөөс амбулаториор 267 хүнд үзлэг хийж, стационариор 12 хүн хэвтүүлэн эмчилж, 0-15 насны хүүхдийн дархлаажуулалтын хамралтыг 100%-д хүргэж, тарилгат халдварт өвчин гаргалгүй ажиллаж байна. Жирэмсний хяналтанд 35 эх хяналтанд байгаа бөгөөд 11 сард шинээр 5 эхийг хяналтанд авсан.

### **Зүүнбүрэн сүм:**

Нутгийн удирдлагын байгууллага үүсч хөгжсөний 25 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулж үе үеийн нутгийн уди рдлагуудад хүндэтгэл үзүүлж, ойд зориулан гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 10 гаруй багийн 50 гаруй тамирчид оролцсон. Мөн сумын ургацын баярыг тохиолдуулан “Алтан намар-2017” сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулан эрэгтэй төрөлд “Андууд”, эмэгтэй төрөлд “Эгч дүүс” баг тэргүүн байранд шалгарлаа.

Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагчдын дунд гар зургийн уралдааныг зохион байгуулж ахлах ангийн төрөлд 10а ангийн сурагч Г.Дөлгөөн, дунд ангийн төрөлд 6а ангийн Б.Мэндбаяр, бага ангийн төрөлд 2б ангийн сурагч Энххүслэн, тусгай байранд 1а ангийн Арвинзул, 3а ангийн О.Агиймаа, 5а ангийн О.Хүслэн нар тус тус шалгарлаа.

Мөн “Төрийн албан хаагчдын өдөр”-ийг угтан “Мэргэжил бүхэн сайхан-Ажил солилцоо” арга хэмжээг зохион байгуулсан.

Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчлах, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.5 дахь заалт, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.4 дэхь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Авлига ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага хамт олон” аян зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2017 оны А/163 тоот захирамжаар байгуулан уг аяны хүрээнд Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагчдын дунд “Би авлигагүй орчинг хүснэ” гар зургийн уралдааныг зарлалаа.

Сумын Засаг даргын захирамжаар Зүүнбүрэн сумын Бэлчирийн 2 дугаар багийн харъяат иргэн Ж.Ганбатын хотонд малын гоц халдварт шүлхий өвчин илэрсэн, Мандал сумаас 1 толгой адуу тээвэрлэгдэж ирсэн тул 2017 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоолоо. Сумын онцгой комиссын даргын 2017 оны 11-р сарын 01 тоот тушаалаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай арга хэмжээг зохион байгуулахаар Онцгой комиссын орлогч дарга, Хөдөө аж ахуйн тасаг, Санхүү албаны дарга, Бэлчирийн 2 дугаар багийн Засаг дарга, багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Соёл мэдээллийн төвийн эрхлэгч, МЭҮН-ийн эздэд үүрэг чиглэл өглөө.

2017 оны ургацын баярын арга хэмжээний хүрээнд “Зүүнбүрэнд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 120 гаруй баялаг бүтээгч иргэн 50 гаруй бүтээгдэхүүн үйлдвэрлэн оролцлоо. Уг арга хэмжээний хүрээнд “Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн”, “Жимс жимсгэний үйлдвэрлэл”, “Оёмол үйлдвэрлэл”, “Шинэ санаа шилдэг бүтээгдэхүүн” зэрэг номинацын эздийг шалгаруулж, Шилдэг зохион байгуулалтай сумаар Мангирт 3 дугаар баг шалгарлаа.

Сумын Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын А/168 тоот захирамжаар Зүүнбүрэн сумын Бэлчирийн 2 дугаар багийн харъяат иргэн Ж.Ганбатын хотонд малын гоц халдварт шүлхий өвчин илэрсэн Мандал сумаас 1 толгой адуу тээвэрлэгдэж ирсэн тул 2017 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоон малыг нийтийн бэлчээрт гаргахгүй байнгын маллагаанд байлгах арга хэмжээ авч ажиллаж байна.

Мал, амьтаны шүлхий өвчин тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг, анхааруулгыг 12 малчин өрхөд сурталчилан ажиллалаа. Газрын нэгдмэл сангаас кадастрын зурагт ороогүй эзэмшил өмчлөлд байгаа талбайд хэмжилт хийж мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж кадастр зураглалын мэргэжлийн байгууллага "Сэлэнгэ тулга" ХХК тай хамтран кадастрын зурагт ороогүй өмчлөлийн газрын 25 иргэний 12.5 га газрын кадастрын зурагт оруулан мэдээллийн санд бүртгэж, шинээр газар өмчилж авах хүсэлт гаргасан 41 иргэнд 20.5 га газрыг шинээр олголоо.

Нийгмийн халамжийн сангаас жирэмсэн, нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 72 иргэнд 2.5 сая, халамжийн сангаас тэтгэвэр авагч 52 иргэнд 7.1 сая, асаргааны тэтгэмж авагч 29 иргэнд 2.0 сая, бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардал 6 иргэнд 120.000, онцгой тохиолдлын амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж авагч 21 иргэнд 1.2 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо.

2017 оны 04 дүгээр сарын 10 –наас хойш шинэ төрсөн 26, овог нэрийн зөрчилтэй 4 хүүхдийг хүний хөгжил сангаас олгож буй 20.000 төгрөгт хамрууллаа.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 5, эцэг тогтоолт 5, гэрлэлт 1, гэрлэлт цуцлалт 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 22, иргэний үнэмлэх гээгдүүлээд дахин авах 2, иргэний үнэмлэх олголтын 15, шилжин явсан 6, шилжин ирсэн 4 нийт 56 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Эрүүл мэндийн төв 24 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулаториор 674 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 125, урьдчилан сэргийлэх үзлэгээр 410, диспансерийн хяналтаар 75, гэрийн идэвхтэй эргэлтээр 48, дуудлагаар 16 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ.

2017 оны 11 сарын байдлаар 0-5 насны хүүхдийн нас баралтгүй. Эх хүүхдийн эндэгдэлгүй, 0-5 насны 1 хүүхэд суулгалт өвчнөөр өвчлөн хэвтэн эмчлэгдлээ. Ээлжит товлотт вакцины хамрагдалт 1 хүртэлх насны хүүхдэд 100% байна. Цусны гемоглобин, тэмбүү илрүүлэх шинжилгээ, ХДХВ шинжилгээг тус тус 3 эхэд хийснээс өвчлөл илрээгүй, умайн болон хөхний үзлэгт 11 эхийг хамруулж 135 эхийг хамрагдахаас 127 эх хамрагдаж хамрагдалт 94,7 хувьд хүрлээ.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон олон нийтийн түвшинд мобайл технологийг нэвтрүүлэх нь төслийн шинжилгээнд 40-65 насны иргэдийн хамрагдалт 90,2 хувьтай хэрэгжиж зорилтот бүлгийн 1518 иргэнийг программд шивж оруулсан.

11 дүгээр сард хүүхэд өдрийн ангид 2750 хүүхэд өдөр хамруулахаас 2487 хүүхэд өдөр хамруулж 90.4 хувь, 24 цагийн ажиллагаатай бүлгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 400 хүүхэд хоног хамруулахаас 314 хүүхэд хоног хамруулж 78,5 хувьтай байна.

“Ахмадаасаа суралцъя” ажлын хүрээнд ахмад багш Цэгмид 14 дүгээр цэцэрлэгт ажиллан залуу, дунд үеийн багш нар ын хөгжүүлэх үйл ажиллагаанд хамрагдан өөрийн туршлагаа хуваалцан арга зүйн зөвлөгөө өгснөөс гадна Цагааннуур сумын Улсын тэргүүний “Нарлаг” цэцэрлэгийн үйл ажиллагаатай багш, ажилчдаа танилцуулан туршлага судлах ажлыг зохион байгууллаа. Мөн Буриад Улсын Хиагт хотын ГБПОУ <<БРТСиПТ>> техникумд хүүхдийн хоолны технологийн сургалтанд 14 дүгээр цэцэрлэгийн ахлах тогоочийг хамруулж, Улаан-Үүд хотын “Журавлёнок” цэцэрлэг, Ивэлгийн аймгийн “Берёзка” цэцэрлэг ийн хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцлоо.

### **Мандал сум:**

Тус сумын 7 дугаар багийн 42 тоотод оршин суугч иргэн Л.Даваагийн үхэрт энэ сарын 16-ны өдөр халдварт өвчний шинж тэмдэг илэрч 5 үхэрт түргэвчилсэн тестээр дээж авч шинжлэхэд шүлхий өвчтэй болох нь батлагдсан тул сумын Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 405 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоож, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторт илгээсэн шинжилгээний дүнгээр шүлхий өвчний “О” хэвшил болох нь батлагдсан.

Иймд сумын Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 407 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоон дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мал эмнэлэг, үржлийн газраас 989 ширхэг халдвар хамгааллын хувцас, 520 ширхэг хормогч, 805 ширхэг хошуувч, 1200 ширхэг бээлий, 540 ширхэг нүдний шил, 940 ширхэг улавч, 115 ширхэг эдийн тубе, 300 ширхэг ийлдсийн тубе, ОХУ-д үйлдвэрлэсэн 70.000 тун вакцин, 10 ширхэг автомат тариур, 1000 ширхэг тариур, 432 ширхэг ган зүү, 600 ширхэг цусны зүү, 10 ширхэг зүү баригч, 500 ширхэг хуруу шил, 1 мананцаржуулагч аппарат, 137 кг хайкоп, 146 вammeкон, 5 кг экоцит, 60 кг ариутгалын бодис, 2 тн хлорын шохой татан авч шүлхий өвчинд мэдрэг малыг вакцинжуулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийж, сумын онцгой комиссын хурлыг 7 удаа хийж, шийдвэрийг цаг тухайд нь хэрэгжүүлж байна.

Тогтоосон хугацаанд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, явуулахыг зогсоож согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг цэгүүдийг хааж, нийт 13 ШТС-аас 7 шатахуун түгээх станцын үйл ажиллагааг түр зогсоож, Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, голомтын бүсэд үүрэг гүйцэтгэх болон шаардлагатай тохиолдолд ашиглах тээврийн хэрэгслийг шатахуунаар хангах зорилгоор 6 шатахуун түгээх станцыг хязгаарлалтын дэглэмээр ажиллуулж байна.

Төмөр замын тодорхой чиглэлүүдийг хязгаарласны дагуу Сэлэнгэ-Улаанбаатар, Улаанбаатар-Сэлэнгэ, Улаанбаатар-Эрдэнэт-Шарынгол чиглэлийн галт тэргийг Зүүнхараа өртөөнд зорчигч буулгаж, суулгахгүй, Зүүнхараа-Улаанбаатар чиглэлийн галт тэргэнд Мандал сумаас 11 дүгээр сарын 20-ны өдөр ирсэн 138, Явсан 119, 21-ний өдөр ирсэн 163, явсан 356, 22-ны өдөр ирсэн 256, явсан 362, 23-ны өдөр ирсэн 265, явсан 303, 24-ний өдөр ирсэн 254, явсан 326, 25-ны өдөр ирсэн 284, явсан 378, 26-ны өдөр явсан 378, нийт 3582 иргэнд ариутгал халдваргүйжүүлэлт хийж зорчуулав.

Тус сумын ерөнхий боловсролын “Билиг ДБ”, Хэрх, 1, 2, 3, 4 дүгээр сургууль, Зүүнхараа политехникийн коллежийн 4225 сурагч, 605 багш, ажилчид, Олимп, Нархан, Тарни, Монохон, Түнхэл, Мишээл, Цэцэгхэн, Янзагахан цэцэрлэгийн 1957 хүмүүжигч, 237 багшажилчид, нийт 6182 Сурагч, хүмүүжигч, 842 багш, ажилчдын үйл ажиллагааг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн ажлын 14 өдрийн хугацаатай түр зогсоосон.

Улсын онцгой комисс, аймгийн Онцгой комисс, сумын Онцгой комиссын өргөтгөсөн хурал 11 дүгээр сарын 20-ны өдөр болж, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, шүлхий өвчний нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүнг хэлэлцэж, ванцинжуулалтын ажлыг эрчимжүүлэх, Зүүнхараа өртөөгөөр дамжин Улаанбаатар хотод зорчих иргэдийн халдваргүйтлийг чанартай хийж гүйцэтгэх, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, айл өрх болгонд мэдэгдэл хүргүүлэх, орон нутгийн телевизээр мэдээлэл хийх үүрэг чиглэл өгсөн.

11 дүгээр сарын 26-ны өдрийн 20:00 цагийн байдлаар 119 айлаас дуудлага ирж 853 үхэрт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэн. Үүнээс 74 айлын 1480 үхэрт үзлэг хийж 608 үхрийг тусгаарлаж, өвчилсөн малыг устгах ажлууд хийгдэж байна. Мөн нохой устгалд 6 хүн 2 автомашинтай энэ сарын 22-25-ны өдрүүдэд 130 нийт 296 нохой устгалаа.

Сумын төвийн голомтын бүсэд 8 бүлэг (8 малын эмч, 8 бүртгэгч, 16 мал баригч, 9 жолооч, нийт 41 хүн) 818 айл өрхийн 9354 үхэр, 2162 гахай, 1059 ямаа, 244 хонь, нийт 12819 мал, амьтанд вакцин, эрүүл бүсэд 6 бүлэг (6 малын эмч, 6 бүртгэгч, 12 мал баригч, 6 жолооч, нийт 30 хүн) ажиллаж 533 айл өрхийн 13860 үхэр, 125 гахай, нийт 13985 мал, амьтан вакцинжуулж, нийт 1354 айл өрхийн 23214 үхэр, 2287 гахай, 1059 ямаа, 244 хонь, нийт 26804 мал, амьтныг вакцинжуулав. Сумын хэмжээнд 34716 мал, амьтан вакцинд хамруулахаас 77.2 хувийг хамруулаад байна.

Мал нь өвчилсөн 103 айл өрхийн хашаа, саравчны 55285 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн.

Мандал суманд “Хүн чулуу”, “Холбоо толгой”, “Шивэр”, “Ажнайн даваа”, төв замаас салдаг “Бороогийн уулзвар”, “Бөө булаг”-ын даваа, “Зараатолгой” гэсэн 7 хяналтын цэгт Онцгой байдлын албанаас 6, Цагдаагийн байгууллагаас 7, Орон нутгийн 7 иргэн, Хөдөлгөөнт эргүүлээр Онцгой байдлын албанаас 8, Цагдаагийн байгууллагаас 10, нийт 38 хүн үүрэг гүйцэтгэж байна. “Спирт Бал Бурам” ХК, Улаанбаатар төмөр замын Ачааны вагон депо хамтран ариутгал, халдваргүйтгэлийн 2 камер хийж 11 дүгээр сарын 20-ний өдөр хяналтын цэгүүдэд байрлуулан ашиглалтад оруулж Улаанбаатар хотоос Мандал суманд ирсэн 9 автомашин, 29 иргэнийг нэвтрүүлэн, Мандал сумаас 17 автомашин, 56 иргэнийг ариутгал, халдваргүйжүүлэлтэд оруулан гаргаж, түр зөвшөөрөлгүйгээр замын хөдөлгөөнд оролцсон 4 жолоочийг бүртгэлд авч байна.

Шүлхий өвчинтэй тэмцэх талаар Сумын онцгой комиссоос авч байгаа арга хэмжээ, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх зорилгоор орон нутгийн телевизээр мэдээлэл өгч, худалдааны гудамжинд байрлах чанга яригчаар иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг өгч ажиллалаа.

Мандал сумын хэмжээнд махны худалдаа эрхлэгчдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж Улаанбаатар хотоос мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэх асуудлыг шийдвэрлэж 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 35 тн мах, махан бүтээгдэхүүн, 650 тн нүүрс татан ирүүлж, түлшний мод, нүүрс, талх, нарийн боов, малын тэжээлээр хуваарийн дагуу хангаж байна.

Мөн голомтын бүсэд Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн, Хүмүүнлэг тусламжын газраас 0.5 тн цагаан будаа, 3 тн гурил, 0.2 тн ургамлын тос, 0.5 тн элсэн чихэр 0.4 тн үхрийн мах нийт 4.850 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, Улсын нөөцийн 3 дугаар салбараас 3.5 тоннын даацтай ариутгал, халдваргүйжүүлэлтийн автомашины тусламж үзүүлж, малын гоц халдварт шүлхий өвчний халдвар, тархалыг зогсоох үйл ажиллагаанд ашиглаж байна.

Цаашид малын тэжээлийн нөөцөд 175 тн өвсийг малтай айл өрхүүдийн хэрэгцээнд Улаанбаатар хотоос татан ирүүлэхээр ажиллаж, малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд улсын Онцгой комиссын шуурхай бүлэгт 5, сумын Онцгой комиссын шуурхай штабт 18, устгалд 29, голомтод 17, байнгын хяналтын цэгт 14, вакцинжуулахад 25, ариутгалд 9, хөдөлгөөнт эргүүлээр 21, эмнэлэгээс 8, санхүү аж ахуйгаас 7 нийт 156 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

### **Орхон сум:**

Сумын нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу “Авилга ашиг сонирхолын зөрчилгүй байгууллага, хамт олон хөдөлгөөн өрнүүлэх” заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын хэмжээнд “Авилгагүй нийгмийн төлөө хамтдаа” сарын аяныг 2017 оны 11 сарын 01-ний өдрөөс 1 сарын хугацаатайгаар зохион байгуулж байгаагаас гадна мөн үндсэн чиглэлийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Сумын хөгжилд-Хүүхдийн оролцоо” сумын хүүхдийн анхдугаар чуулганыг хийж, орон нутгийн түвшинд хүүхдийн дуу хоолойг сонслоо. Чуулганы үеэр “Мэргэжил сонголт”, “Амжилттай суралцахын үндэс, хүүхэд нэг бүрийн оролцоо”, “Цахим гадуурхал цаашаа”, “Гэр бүлийн аз жаргал” зэрэг илтгэлүүдийг сумын Засаг дарга, сургуулийн захирал, нийгмийн ажилтан, эцэг эхийн зөвлөлөөс сонордууллаа.

Сумын Засаг дарга Г.Бат-Орхоны санаачилгаар Орхон бүсийн Засаг дарга нарын нэрэмжит “Эх хэлдээ эзэн нь байя” монгол хэлний хичээлийн стандарт олимпиадыг Орхон бүсийн 8 сургуулийн 6-12-р ангийн сурагчдын дунд зохион явуулахад нийт 177 сурагч, 16 багш амжилттай оролцлоо.

Тайлант хугацаанд аймгийн Биеийн тамир, спортын газар болон Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгууллагуудын үндэсний холбооны Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл хамтран зохион байгуулсан “Монгол наадгай” өдөрлөг, тэмцээнд 8 сумын 80 гаруй тамирчид оролцож оюун ухаанаа сорьсноос Хөлөгт тоглоомын төрөлд тус сумын иргэн М.Дорждамба, Д.Лхагвасүрэн нар алтан медаль, шагай

няслах төрөлд Ч.Отгонбаяр мөнгөн медаль, морь уралдуулах төрөлд иргэн Д.Жаргал мөнгөн медалийг тус тус хүртсэн.

11 сарын байдлаар нийт давхардсан тоогоор 668 иргэнд 171,296,740 төгрөгийг тус тус олгож, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 5 өрхийн 46 иргэнд 10 сарын хүнсний эрхийн бичгийг олгож нийт 286000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж ажилласан.

Нийгмийн даатгалын шимтгэлд төсөвт аж ахуй нэгж байгууллагаас шимтгэлийн орлого 17346,4 мянган төгрөг, сайн дурын даатгалд 35 даатгуулагчийн 1536,3 мянган төгрөг, ЭМД-д 30 даатгуулагчийн 1728,0 мянган төгрөгийг санд оруулж, тэтгэврийн даатгалын санд 6226,2 мянган төгрөг, тэтгэмжийн санд 2000,0 сая төгрөг, ҮОМШӨ-ий санд 320,0 мянган төгрөг, ЭМД-ын санд 4500,0 мянган төгрөг, ажилгүйдлийн санд 370,0 мянган төгрөг мянган төгрөгийн хуваарилалтыг хийж тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд олголоо.

Аймгийн аялал жуулчлалын бүс байгуулахтай холбогдуулан тус сумын хэмжээнд байгаа түүхийн дурсгалт газар болох “Нарт хайрхан” уул, Хүн чулуу, Буган хад, Буган хөшөө, Люваанжалба бурханзэрэг нийт 8 газрыг координатжуулах, гэрэл зургаар баримтжуулах ажлын хэсэгтэй хамтран ажилласан. Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт “Зөвлөмж, үүрэг даалгавар хүргүүлэх тухай” 2017 оны 01/24 тоот, Хууль бус мод бэлтгэлтэй тэмцсэн ажлын тайлан, 2017 оны 01/445 тоот “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан тоотын дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж хүргүүлсэн.

Орхон хонины зохиомол хээлтүүлгийн ажлыг сумын Засаг даргын 2017 оны А/135 тоот захирамжаар 10-р сарын 30-аас 11-р сарын 11-ний хооронд агьтийн хошуунд зохион байгуулж, СҮЦСАА-н 350 эм хонь, “Мангиртрейд” ХХК-ний 150 эм хонь, 1 иргэний 29 эм хонь, бүгд 529 эм хонь хамрагдлаа. Мөн Орхон хонь малладаг 5 өрх, 1 аж ахуйн нэгжийг хуцаар хээлтүүлгэнд 826 эм хонь хамруулсан

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлтэй 10 иргэний материалыг Сайхан сум дахь сум дундын шүүхэд 7, шүүхийн шийдвэр гүйцэтгэх рүү 3 материал бүрдүүлэн өгсөн.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн нийт 141428888 төгрөгийн гүйлгээ хийгдсэн. 2017 оны төсвийн гүйцэтгэлийн 10-р сарын мэдээг гаргаж /shilendans.gov.mn/ шилэн дансны цахим хуудсанд мэдээлэлийг байршуулсан.

Монгол Улсад нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг угтаж сумын ИТХ-аас “Сумын хөгжилд-сурагчдын оролцоо” сэдэвт сурагчдын анхдугаар мини парламентыг зохион байгуулж, Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн шилдэг 21 сурагч оролцон, гарсан саналыг сумын ИТХ-д хүргүүлсэн.

“Амттан бүхэн манай ангид” ургацын баярыг I-XII ангийн сурагчид, эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгуулж, хамгийн том хүнсний ногоо тарьсан сурагчийг шалгаруулан, манлайлан оролцсон ангиудад өргөмжлөл гардууллаа.

“STEAM” сургалтын хэрэглэгдэхүүнээр сурагч нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааг II-V ангийн сурагчдад 7 хоногт 2 цаг судлахаар хичээлийн хуваарьт тусгаж, математик, дүрслэх урлаг, хүн байгалийн хичээлтэй уялдуулан анги удирдсан багш нар удирдан хичээллүүлж байна.

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр III шатны төслийн хүрээнд хэрэгжиж буй “Мөрөөдөлд зам бий” төслийн хүрээнд БАХҮА-ны баг хамт олон I-V ангийн сурагчдыг “Жиргээ” шүлгийн дугуйлан, “Оюуны нахиа” сэтгүүлчийн дугуйлан, “Гэрэлт ирээдүй” жүжгийн дугуйлан, “Шидэт бийр” зургийн дугуйланд тус тус бүртгэл хийж, хүүхэд хөгжүүлэх вакум танхим, уран зургийн хэрэгсэл, хөл, хавтан 10ш, EPSONR1390A3 өнгөт принтер 1ш, 40 инчийн HAIER брэндийн Led зурагт 2 ширхэгийг авч сурагчдын сурах таатай орчныг бүрдүүллээ.

Сурагчдын ном унших чадвар, авьяасыг нээн хөгжүүлэх, тэднийг өөрийгөө илэрхийлэх, бусдыг сонсох хүндэтгэх зөв дадалд сургах зорилгоор “Ном миний үнэнч



анд” аяныг өрнүүлэн, амжилттай хэрэгжүүллээ. Тус аяны хүрээнд I-XII ангийн сурагчид “Ном миний үнэнч анд ” сэдэвтэй ханын сонин гаргах, сурагч бүр “Уншсан номын тэмдэглэл”-хөтлөх, тэмдэглэлээрээ үзэсгэлэн гаргах, сургамжит өгүүллэг зохиох, анги бүрээс шалгарсан “Уран уншигч” сурагчид өөрийн сонгосон шүлгээр уран унших зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

БУХҮА-багийн сарын аяны хүрээнд сурагчдын стандарт мэдлэгийг бататгах, чадварыг хөгжүүлэх хөтөлбөрт ажил–3, мини олимпиад–4, эцэг эхийн танин мэдэхүйн тэмцээн–1, судалгаат хичээл–1, “Сургалтын ухаалаг хэрэглэгдэхүүнийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах нь илтгэл–1, “Сургалтын идэвхтэй аргаа хуваалцах цаг” багш нарын сургалт–1 зохион байгуулахад давхардсан тоогоор 313 сурагч, 18 багш, 12 эцэг эх оролцсон байна.

Орхон сумын цагдаагийн төлөөлөгч ахлах ахлагч Баярсайхан дотуур байрны VIII-XII ангийн сурагчдын дунд “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” тухай сургалтыг зохион байгуулж, сурагчдад олон нийтийн газар хэрхэн биеэ зөв авч явах хуулийн мэдлэгийн зөвлөгөө өгч ажиллалаа.

Орхон 12-р цэцэрлэг нь 2017 оны 10-р сарын 20-ноос 11-р сарын 20 хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 1609 хүүхэд хүлээн авч СӨБ олгон ажиллалаа. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын “ЦӨМ” хөтөлбөрийн дагуу “Миний орчин-манай анги” сэдвийн хүрээнд 7 чиглэлээр 72 удаагийн хөгжүүлэх үйл ажиллагааг зохион явуулж хүүхдийн мэдлэг чадвар дадлыг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Цэцэрлэгийг цэвэр усанд холбох, дотроо бие засах өрөөтэй болох ажлуудыг дэс дараатай зохион явуулсаны үр дүнд цэцэрлэгийн хашаанд гүний цэвэр усны худагтай болж, хүүхдүүдийн цэвэр дулаан орчинд бие засах боломжийг ханган ажиллаж нэн түрүүнд тулгамдаж байсан асуудлуудыг шийдвэрлэлээ. Дэлхийн гар угаах өдрийг тохиолдуулан эрүүл мэндийн төвөөс хүүхдүүдэд гар угаах сургалтыг зохион явуулан бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн “ АХА ” тэмцээн явууллаа. Мөн багш нарын дунд түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өглөө. Аймгийн БСУГ-аас цэцэрлэгүүдийн эрхлэгч, тогооч нарыг ОХУ-ын Улаан-Үдэ хотноо 2017 оны 11 сарын 10-12-ны өдрүүдэд сургалтанд хамруулсан бөгөөд тус сургалтанд эрхлэгч З.Туяацэцэг, тогооч П.Орхончимэг нар хамрагдан цэцэрлэгийн сургалт, орчин, эрүүл ахуй, хоолны чанар зэрэгт туршлага судлан ажиллалаа.

Эрүүл мэндийн төвийн даргын 2017 оны 11 сарын 10-ны өдрийн А/17 тоот тушаалаар Халдварт өвчнөөс сэргийлэх, тандалт хийх, өвчлөлийг таслан зогсоох хянах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон “Сүрьеэгүй сум” Томуу, томуу төст өвчлөлийг бууруулах ажлын төлөвлөгөө гаргасан ажиллаж, “Элэгтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх нь”, “Саралтай тусламж үйлчилгээ”, “Антибиотикийн зохистой хэрэглээ” сургалтыг эмч, эмнэлгийн 14 хүнд зохион байгуулсан.

Тайлант сард нийт эмчийн үзлэг-162, Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг 149 буюу 91%-тай байна. Нийт түргэн тусламжийн дуудлага 60 үүнээс алсын дуудлага 12 ирсэн нь өмнөх сараас 27.5%-иар буурсан байна. Дуудлагын хуваарийн дагуу цаг тухайд хүрч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, 24 иргэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, тусламж үйлчилгээ авч байна.

### **Сант сүм:**

2017 оны ургац хураалтын ажил дуусч 1731 га талбайгаас 1720,3 тн улаанбуудай, 2 га талбайгаас 3,6 тн овьёос, 200 га талбайгаас 3100 тн төмс, 125,1 га талбайгаас 1727,3 тн хүнсний ногоо тус тус хураан авсан байна. ХАА-9а, ХАА-9б маягтаар 132 иргэн, 4 аж ахуйн нэгжийн ургац хураалтын мэдээг гаргаж статистикийн програмд шивэх ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байна.

Сумын хэмжээнд улаанбуудайн борлуулалтын мэдээг гаргаж 1720,3 тн улаанбуудай хураан авснаас өөрийн үрэнд 252,1 тн, тэжээлд 174,6 тн, гурилын үйлдвэрт 746,4 тн, спиртийн үйлдвэрт 240 тн, ТЭДС-нд 307,2 тн тус тус борлуулсан байна. Гурилын үйлдвэр болон ТЭДС-д улаанбуудай тушаасан аж ахуйн нэгжүүдийн материалыг хүлээн авах ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн ЗДТГ, Хүнс, Хөдөө аж ахуйн газраас хамтран зохион байгуулсан “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах арга зүй” сэдэвт сургалтанд 11 ногоочин хамрагдсан байна.

Мандал суманд гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан сумын Засаг даргын захирамжаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилон сумын хэмжээнд үхэр болон гахай сүрэгт тандалт үзлэгийг хийж аймгийн мал эмнэлэгийн газарт мэдээлж ажиллахаас гадна мал амьтны шилжилт хөдөлгөөний түр хугацаагаар хязгаарлан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 21-р хорооноос түр хугацаагаар оршин сууж байгаа малчин Д.Батхуягийн суурийн 35 үхэрт тандалт үзлэг хийж ариутгал халваргүйжүүлэлт хийсэн. Мал оторлолтын судалгааг гаргаж Булган аймгийн Булган сумаас 563 толгой малтай нэг малчин отроор суурьшихаар ирсэн бол сумаас 377 толгой малтай нэг малчин Хэнтий аймгийн Хэрлэн баян улааны отрын бүс нутагт оторлож яваа болно.

Аймгийн Онцгой байдлын газарт сумын малчин өрхийн судалгааг гаргаж мэдээлсэн ба судалгаагаар Ивэн 1-р багт 112 малчин өрхийн 432 хүн ам, жирэмсэн эх 3, 0-5 насны хүүхэд 45, өндөр настан 27, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 20, Хушаат багт 116 малчин өрхийн 502 хүн ам, жирэмсэн эх 5, 0-5 насны хүүхэд 37, өндөр настан 18, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 9 тус тус бүртгэгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны А/300 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын махны жилийн хэрэгцээ, борлуултын судалгаануудыг гаргаснаас сумын хэмжээнд 0,9 тн адууны, 36,9 тн үхрийн, 42 тн хонины, 8,7 тн ямааны мах хэрэглэж байна. Малчид зун, өвлийн турш адууны 57, үхрийн 324, хонины 1804, ямааны 568 нийт 2753 гулууз махыг Дархан Уул аймгийн хүнсний зах дээр борлуулаад байна.

Сумын ЗДТГ, албан бус боловсролын Гэгээрэл төвтэй хамтран малчдад бүлгээр ажиллахын ач холбогдол, малчдын бүлгүүдийн ажиллах зарчим, хурал зохион байгуулах, бүлгийн ажлын дэвтэр хөтлөх, бүлгийн дотоод журам боловсруулах нь сэдвүүдээр сургалт зохион байгуулан гэрийн эзэгтэй нарт зүү ороох аргаар хөөрөгний даалин оех сургалт зохион байгуулж 9 өрхийн 15 малчин хамрагдсан байна.

Бог малын хээлтүүлэг дуусч байгаатай холбогдуулан 2018 онд хуц ухна маллах малчныг өргөдөл, хүсэлтийн дагуу сонгож гэрээ хийн хуц ухныг ялгаж суурилах ажлыг хийгээд байна.

Нийгмийн даатгалын шимтгэл нэг удаа төлүүлж ажилласан жил нөхүүлэх ажлын хүрээнд хийгдэж байгаа 228 малчин өрхийн судалгааг гарган аймгийн хүнс хөдөө аж ахуйн газарт явуулсан байна.

2017 оны 11-р сарын байдлаар суманд 14 шинэ ажлын байр бий болсныг бүртгэж 10 иргэнд ажилд зуучлах үйлчилгээ үзүүлсэн байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгээр зөвлөгөө өгөх үйлчилгээнд ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 9-12 дугаар ангийн 58 сурагчид хамрагдаж аймгийн ХХҮГ болон Улаанбаатар хотын “Хүний хөгжил судалгаа” сургалтын төвтэй хамтран “Мэргэжил сонголт” хичээлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

2017 оны 11-р сарын 09-ны өдөр сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл хуралдаж 81,0 сая төгрөгний санхүүжилт хүссэн 12 иргэний төслийг хэлэлцэж 10 иргэнд 45,5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлээд байна.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөнд хэрхэн оролцох, насанд хүрээгүй хүүхэд тээврийн хэрэгсэл жолоодох тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар мэдээлэл хийж 6-12 ангийн 50 гаруй сурагч хамрагдсан байна. Мөн долоо хоног бүрийн Лхагва гаригт архи согтууруулах ундаагаар үйлчилэхгүй, худалдан борлуулахгүй байх сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын

хүрээнд ГХУСАЗСЗ-ийн гишүүд хариуцлагатай эргүүл хяналтын ажлыг хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төвтэй хамтран байнгын асаргааны тэтгэмж авдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдийг асарч буй асрагч нарт зориулсан “Байнгын асаргааны асрагч нарт зориулсан чадавхижуулах” сургалтыг зохион байгуулж “Зөрчлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Ахмад настны тухай хууль”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” –иар мэдээлэл хийж “Хүнд өвчтөнд хийх асаргаа сувилгаа” сэдэвт үзүүлэх сургалтыг зохион байгуулж 16 байнгын асрагч хамрагдсан байна.

Улс тунхагласны өдрийг угтаж сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд урлаг, спорт баярын арга хэмжээ зохион байгуулагдаж ажил үйлс, урлаг спортын шилдгүүдээ шалгаруулсан байна. Энэ үеэр төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулагдаж 1 албан хаагч тангараг өргөсөн байна.

Орон нутгийн татварын орлого 38963,4 мянган төгрөг орохоос 77689,5 мянган төгрөг төвлөрч гүйцэтгэл 199,4 хувьтай орлого 38729,1 мянган төгрөгөөр даваад байна. Аймгаас авах санхүүгийн дэмжлэг 166277,5 мянган төгрөгийг авч орон нутгийн байгууллагуудад 237715,5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоос 237673,9 мянган төгрөг олгож гүйцэтгэл 99,9% хувьтай байна.

Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилийн 1-р улирлын дүн гарч 140 сурагч бүрэн дүгнэгдсэнээс А-38, В-32, С-40, D-30, F-0 стандарт хангалт 100%, АВ-ийн эзлэх хувь 50.0%-тай байна.

Сумын “Авьяаслаг хамт олон” шалгаруулах аяны хүрээнд зохион байгуулсан спортын арга хэмжээнд нийт 8 багийн тамирчид шатар, даам, дартс, теннис, хөгжилтэй буухиа, гар бөмбөг зэрэг тэмцээнүүдээр амжилттай оролцлоо. Аяны 2-р шат болох урлагийн тоглолтын арга хэмжээ явагдаж байна.

Орхон бүсийн ахмадуудын урлаг, спортын арга хэмжээ амжилттай зохион байгуулагдаж “Бид нэг үеийнхэн” шоу цэнгээн арга хэмжээнд 6 сумын 100 гаруй ахмадууд оролцсон байна.

Тайлант хугацаанд Соёлын төвийн номын сангаас давхардсан тоогоор 240 уншигчдад 278 ш номоор, танхимын уншлагад 56 иргэд, хүүхдүүдэд 68 ширхэг ном сэтгүүлээр үйлчилсэн. УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат сумын иргэд, хүүхэд залуучуудад оюуны хөрөнгө оруулалт хийж 465.000 төгрөгийн үнэ бүхий 51 ширхэг ном хандивлаж, шинэ номын үзэсгэлэн гаргаж уншигчдын хүртээл болгосон байна.

### **Цагааннуур сум:**

2017 онд сум хэмжээнд нийт 28763 га-д үр тариа тариалснаас 31322 тн буюу 12,8 цн, рапс 5542 га-гаас 1398 тн буюу 4,5 цн, хадлан 11616 тн-ыг тус тус бэлтгэсэн. 11-р сарын 5-ны өдөр сумын тариаланчид ургацын баяраа тэмдэглэн, баярын хурал, урлагийн тоглолт, хүчит бөхийн барилдааныг зохион байгууллаа. Хурлын үеэр ХХААХҮ-ийн тэргүүний ажилтан цол тэмдгээр “Баяндулаан-Уул” ХХК-ий механикжуулагч Д.Батбуян, аймгийн ИТХ-ын хүндэт өргөмжлөлөөр “Нарийн шүрэн” ХХК-ний захирал Д.Батцогт, тариаланч Х.Болд, аймгийн Засаг даргын Жуух бичгээр “Бургастайн хишиг” ХХК-ний агрономич С.Мэндсайхан, “Нарийн шүрэн” ХХК-ий механикжуулагч С.Өлзийхутаг, “Баянсэлэнгэ” ХХК-ний механикжуулагч Э.Бат-Эрдэнэ, “Номунхан” ХХК-ний тогооч Г.Энхжаргал, “Атартрейд” ХХК-ий нягтлан бодогч Ө.Отгонбаяр, сумын Засаг даргын жуух бичгээр 11 иргэн, сумын ИТХ, Засаг даргын өргөмжлөлөөр 21 иргэн тус тус шагнагдлаа. 2017 онд 5500 тн ургац хураан авсан амжилтыг үнэлж Одгэрэл захиралтай “Сэлэнгэ тариа” ХХК-ний хамт олон, 4077 тн ургац хураан авсан амжилтаар Ө.Чимэддорж захиралтай “Атартрейд” ХХК-ний хамт олон, усалгаатай талбайгаас 1 га-аас 35,4 цн ургац хураан авсан амжилтаар Б.Мөрөн захиралтай “Баяндулаан-Уул” ХХК-ний хамт олонд дурсгалын зүйл гардуулж, тариаланч хамт олондоо зориулан дуучин Б.Нямзагд, Б.Хандмаа нарын урлагийн тоглолтыг толилууллаа. ■ Хүчит бөхийн барилдаанд хүчит

32 бөх уран мэхийг уралдуулан барилдсанаас Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын харьяат 5 хан дэвжээний бөх сумын Заан Б.Очирхуяг түрүүлж, Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат 5 хан дэвжээний бөх Н.Баярбаатар үзүүрлэлээ.

Мөн энэ сарын 04-ний өдөр “Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл” эрхлэгч иргэдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг сумын Соёлын төвд зохион байгуулж, нийт 21 иргэн 6 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, шилдэгийн шилдэг бүтээгдэхүүнээ тодрууллаа.

1. Шилдэг “Гурил гурилан бүтээгдэхүүн”-ээр 2 дугаар багийн иргэн Б.Мөнхжаргал
2. Шилдэг “Сүү сүүн бүтээгдэхүүн”-ээр 1 дүгээр багийн иргэн Д.Нарантуяа мөн дэд байранд Д.Цогзолмаа
3. Шилдэг “Мах махан бүтээгдэхүүн”-ээр 3 дугаар багийн иргэн Батэрдэнэ
4. Шилдэг “Жимс жимсгэний бүтээгдэхүүн”-ээр 3 дугаар багийн иргэн С.Амаржаргал
5. Шилдэг “Хүнсний ногооны бүтээгдэхүүн”-ээр 2 дугаар багийн иргэн Г.Үүрцайх, мөн дэд байранд Д.Сумьяажав
6. Шилдэг “Оёдол гар урлалын бүтээгдэхүүн”-ээр 3 дугаар багийн иргэн Ц.Ичинхорлоо нар тус тус шалгарсан байна.

Үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэд 2,801,000 мянган төгрөгийн борлуулалтыг хийсэн байна.

Сумын ИТХ-ын ээлжит 8 дугаар хуралдаан 11-р сарын 22-нд болж, сумын 2017 оны төсвийн тодотголыг хэлэлцэн баталсан.

Мөн сумын ЗДТГ-ын ажилтнуудын шуурхай хурлыг 3 удаа зохион байгуулж цаг үеийн мэдээлэл өгч, хууль, эрх зүйн сургалт сурталчилгааг 6 удаа зохион байгуулсан.

Энэ сарын 15,16-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Сумын хамтарсан багийн сургалт, “Бид Цагааннуурын ирээдүй” хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан.

“Иргэний Андгай Өргөх Ёслол”-ыг 11-р сарын 23-ны өдөр зохион байгуулж, баяр хүргэн иргэний үнэмлэхийг нь гардуулан өгсөн. Монгол улс анхдугаар үндсэн хуулиа баталж, бүгд найрамдах улсаа зарлан тунхагласны 93 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх мөн нийт төрийн албан хаагчдын уялдаа холбоог сайжруулах, тэднийг спортод хандах идэвх сонирхлыг өрнүүлэх зорилгоор зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээнд төсвийн байгууллагын эрэгтэй 4, эмэгтэй 6 баг өрсөлдсөнөөс эрэгтэй тэргүүн байранд сургуулийн баг тамирчид, 2-т ЗДТГ-ын 1-р баг, 3-т ЗДТГ-БОХ баг, эмэгтэй баг тамирчдаас Цэцэрлэгийн баг тэргүүн байр, 2-т Сургууль, 3-т ЗДТГ-1-р баг тус тус шалгарсан байна. Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-д заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолд сумын төрийн захиргааны албан хаагч Х.Дашцэрмаа оролцож, төр, ард түмнийхээ төлөө үнэнч шударга ажиллахаа илэрхийлж, төрийн далбаандаа хүндэтгэл үзүүлэн тангаргийн бичигт гарын үсэг зурлаа.

Тэтгэврийн даатгалын сангаас 383 өндөр настанд -104764,8 мянган төгрөг, 59 тэжээгчээ алдсан иргэнд 13718,7 мянган төгрөг, 189 тахир дутуу иргэнд 47062,9 мянган төгрөг, 4 цэргийн өндөр настанд 12270,1 мянган төгрөг, ҮОМШӨД-ын сангаас 5 иргэнд 13086,0 мянган төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 19 даатгуулагчдад 1604,0 мянган төгрөг, жирэмсэн, амаржсан 4 эхэд 6062,2 мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 1 иргэнд 1000,0 мянган төгрөгийг тус тус олголоо.

Сумын татварын орлого 11 дүгээр сард 80323.8 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 11 сарын 27-ны байдлаар 101613.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, 126.5 хувийн биелэлттэй байна. Аймгийн аудитын газраас Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар суманд ирж сумын төсөвт байгууллагуудад хяналт шалгалт хийсэн ба шилэн дансанд мэдээллэсэн мэдээ мэдээллийг байгууллагын нягтлан бодогч нар анхан шатны баримтын хамт шалгуулж, төрийн сангийн нөөцөнд бүртгүүлэх хүмүүсийн судалгаа гарган явуулсан. Мөн мэргэжлийн

нягтлан бодогчийн тангараг өргөх ёслолд аж ахуй нэгжийн болон төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтэн нийт 11 хүн тангараг өргөсөн байна.

Тариалангийн талбайд мал ихээр орж зөрчил их үүссэнтэй холбогдуулан тариаланч малчдын уулзалтыг “Гацуурт” ХХК-ний удирдлага, малчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, 48 малчин өрхийн төлөөлөл хамрагдаж намар тариа хурааж дууссанаас хойш тодорхой хугацаанд хашаалсан тариалангийн талбайд мал бэлчээх хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулахаар ажиллаж байна. Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн баталгаажуулалтын шинжээч, улсын шалгагч, байцаагчид 11 дүгээр сарын 7,8-ний өдрүүдэд суманд худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн ажлын байранд холбогдох стандартын дагуу ээлжит тохирлын үнэлгээ хийв. Тохиролын үнэлгээнд хүнсний мухлаг 1, талх нарийн боовны цех 1, дэн буудал 2, цайны газар 2 тус тус хамрагдав.

### **Сайхан сум:**

Тайлант хугацаанд “Хүлээж биш хүрч үйлчилье” нээлттэй хаалганы өдөрлөгийг сумын хэмжээнд зохион явуулж, сум дундын цагдаагийн хэлтэс, сум дундын эмнэлэг, аврах гал унтраах 61-р анги, сумын наториатч нар иргэдэд үйлчилсэн. Мөн “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний шинэчлэл” 3-н үе шаттай арга хэмжээний 2-р үе шат болох Хишиг өдөр” арга хэмжээг 2017 оны 11-р сарын 13-21-ний өдрүүдэд зохион байгуулж, сумын хэмжээний нийт 19 төрийн байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг үзүүллээ.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, сумын “Хүүхэд хамгаалах хамтарсан” багийн гишүүд Улаанбаатар хотод ажиллаж хүний эрхийн хуульч М.Ичинноров, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, “Лантуун Дохио” ТББ-уудын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан зөвлөгөө мэдээлэл авлаа.

2017 онд сумын дүнгээр улаан буудай 13291 га-д тариалж, га-наас 11.5 цн буюу 15284.6 тн, рапс 2066 га-д тариалж, га-аас 5 цн буюу 1033 тн, малын тэжээл /маалинга/ 40 га-д тариалж, га-аас 8 цн буюу 32 тн, арвай 30 га-д тариалж, га-аас 6 цн буюу 18 тн, овъёос- 25 га-д тариалж, га-аас 5 цн буюу 12.5 тн, төмс 256 га-д тариалж, га-аас 120 цн буюу 3072 тн, хүнсний ногоо 243.6 га-д тариалж, га-аас 120 цн буюу 2923.2 тн-ыг тус тус хураан авсан. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн А/105 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ургамал, түүний гэрэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гэрэл, үүслийн гэрчилгээг”-г нийт 18 улаанбуудай болон төмс, хүнсний ногоо тариалсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон байна.

Номгон тосгоны захирагчийн албанаас санаачлан “Малчдын нэг өдөр” урлаг, спортын арга хэмжээ, үдшийн цэнгүүнийг энэ сарын 18-ны өдөр зохион байгуулж, 300 гаруй иргэн оролцлоо.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн албан тоотын дагуу “Гацуурт” ХХК-д үржүүлж буй махны чиглэлийн хар, улаан ангус үүлдрийн бухнаас суманд 4 толгой бухыг авч ирж Номгон 3-р багт 2, Хөтөл 1-р багт 1 толгой бухыг хувиаарлаж малчдад хүлээлгэн өгсөн байна.

Сайхан сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нэгж нь 11-р сарын тайлангийн хугацаанд нийт 222 мэдүүлэг авч Монгол Улсын үндсэн хууль, Иргэний тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад эрх зүйн актууд болон дээд шатны байгууллагын чиглэл заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2017-2018 оны хичээлийн жилийн 1-р улирлын үнэлгээ гарч Хөтөл ЕБС, Номгон ЕБС-ийн 1-5-р ангийн сурагчдад чадварын үнэлгээ хийгдлээ. Хөтөл ЕБС-д

Дунд, ахлах ангийн 727 суралцагч дүгнэгдэхээс 725 суралцагч дүгнэгдэж ABCD- 89,1% , ABC– 39,7%, AB – 18%-тай үнэлэгдлээ.

Тайлант хугацаанд “Математик цаг” сонины нэрэмжит математикийн стандарт олимпиадад 274 суралцагчийг, 11-р сарын 11-нд Орхон суманд Орхон бүсийн сургуулиудын 6-12 рангийн сурагчдын Монгол хэл бичгийн олимпиад 35 суралцагчийг оролцуулснаас гадна Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас зохион байгуулсан “Мэргэжил сонголт- мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалтанд 12-р ангийн 141 суралцагч хамрагдаж, энэ сарын 13-нд “Аз хур” номын дэлгүүрээс орон даяар зарлан явуулсан “Таши Монголд” цуврал ном бүтээх төсөлт уралдаанд Хөтөл ЕБС-ийн 9а ангийн сурагч Мишээл , Хан Саран нар хамтран оролцож тэргүүн байр эзлэн 100000 төгрөгийн үнийн дүнтэй дүйцэхүйц ном сонгон авах эрхээр шагнууллаа.

Мөн Номгон тосгоны ЕБС-иас 2017-2018 оны хичээлийн жилийн сурагчдын “Намрын спартакиад”-ыг зохион байгуулж, нийт 109 хүүхэд 8 багш хамрагдан оролцсон.

Сургуулийн насны хүүхдэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэлээр бүсийн сургуулиудын 3-5-р ангийн сурагчдын дунд уламжлал болон зохиогддог “Ногоон гэрэл – Цагаан шугам -2017 “ тэмцээн Хөтөлийн ЕБС-ийн спорт зааланд амжилттай явагдлаа. Тус тэмцээнд Хөтөлийн ЕБС-ийн Д.Янжиндулам багштай 4б ангийн баг тамирчид Тэргүүн байр эзэлж, Номгон ЕБС-ийн баг 2-р байр эзэллээ. Тус тэмцээнээр хүүхдүүд замын хөдөлгөөний аюулгүй байдал, харгалзах хүнгүй зам хөндлөн гарч болохгүй болох, замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэлийг сургалтуудаар мэдэж авсан.

2017 оны 11-р сард сум дундын эмнэлэгийн хүүхдийн эмч нар цэцэрлэгүүдэд эмчийн үзлэг хийж, шаардлагатай хүүхдүүдэд эмчилгээ бичиж, давтан үзлэгийг эмнэлэг дээр хийж нийт хүүхдүүдийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Жил бүр эцэг эхийн дунд уламжлал болгон зохион байгуулагддаг “Замд гаръя-2017” аялалыг энэ хичээлийн жилд нийгэмд тулгамдаж байгаа асуудлыг тусган “Хүүхэд хамгааллын бодлого”, “Хүүхдийн эрхийн тухай” хуулийг сурталчилан танилцуулах зорилгоор “Хүүхэд хамгааллын төлөө хамтдаа” уриан дор зохион байгууллаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг үндэслэн аймгийн Эрүүл мэндийн газраас өгсөн чиглэлийн дагуу Хөтөл хотын ЦШХК, ТБДҮ, нийт төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, банк санхүүгийн байгууллагууд зэрэг нийт 21 байгууллагыг хамруулан 2017 оны 10 сарын 15 наас 11 сарын 10 ны хооронд бие бялдарын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг, цэцэрлэгт хамрагдсан 3-5 нас, ЕБС-ийн 7-15 нас, насанд хүрэгчдийн 15-64 насны хүн амын дунд ажлын байранд нь очиж авлаа. Сорилд 11, 20, 24 дүгээр цэцэрлэгийн 3-5 насны 373 хүүхэд, ЕБС-ын 6-8 насны 362 хүүхэд, 9-11 насны 168 хүүхэд, 12-17 насны 378 хүүхэд, 17-64 насны 1038 бүгд 2319 хүмүүс хамрагдаж нийт хүн амын 30%-ыг хамрууллаа. Сорилд хамрагдсан 2319 хүнээс 1228 хүнийг нь [www. sport.gov.mn](http://www.sport.gov.mn) программд шивж оруулсан. Сорилд хамрагдсан насанд хүрэгчдийн 1038 хүнээс 291 хүн буюу 28,2% нь таргалалтын 1, 2-р зэрэгтэй байна.

2017.11.15-ны өдөр “МОНГОЛ-ФАРМ” эмийн кампани сургалт зохион явуулж томуугийн улирал эхэлж, хүүхдийн өвчлөл нэмэгдэж байгаатай холбоотой шинэ мэдээллийг эмч, мэргэжилтнүүдэдээ болон орон нутагт эмийн худалдаа эрхлэж байгаа эмийн сангийн мэргэжилтнүүд, цэцэрлэг, сургуулийн эмч нарыг хамруулсан. Сургалтанд нийт 34 эмч, мэргэжилтэн, эмийн сангийн мэргэжилтнүүд хамрагдсан. Мөн сарын 16-ны өдөр сумын ЗДТГ-ын халамжийн албатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй, хүнд хэврийн үйлчлүүлэгч нарын асран хамгаалагч нарт “Гэрийн асаргааны аргачлал” сэдвээр сургалт зохион явуулж, сургалтанд 24 асран хамгаалагч иргэд хамрагдсан.

Сайхан сумын сум дундын Онцгой байдлын гал түймэр унтраах 061-р ангийн 30-н жилийн ойд зориулан Сайхан сумын хэмжээнд “Хөтөл лиг” сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2017 оны 10-р сарын 25-аас 2017 оны 11-р сарын 05-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.

Сайхан сумын чөлөөт уран бүтээлч МУСТА Б.Бадамсүхийн нэрэмжит уламжлал болгон зохион байгуулагддаг “Бид дуулах дуртай” гоцлол дууны уралдаан 11-р сарын 11-ний өдөр соёлын ордонд зохион байгуулсан. Мөн нийтийн бүжгийг нийтэд сургаж, сурталчлах ажлын хүрээнд Хөтөл Соёлын ордны бүжгийн багш Ч.Урангоо төр төсвийн байгууллагын ажилтнуудын дунд нийтийн бүжгийн сургалтыг 14 хоногийн хугацаанд зохион байгуулан хуваарийн дагуу байгууллага тус бүрт нийтийн бүжгийг зааж 2017 оны 11-р сарын 16-ны өдөр албан байгууллагын хооронд “Өвлийн уянга” нийтийн бүжгийн уралдааныг зохион байгууллаа.

Тайлант хугацаанд Монгол Улсын УГЗ Чулуунбатын “Амьдралын бэлэг” уран бүтээлийн аялан тоглолт 11-р сарын 02-нд тоглолт, “Single ladeis”-3 Монголын уран сайхны цоо шинэ кино 11-р сарын 03-нд, “Зүрхний хилэн” Монголын уран сайхны кино 10-р сарын 28-нд Хөтөл Соёлын ордны кино өргөөнд гарсан.

Хөдөлмөр Халамжийн сангаас 10-р сард буюу 3-р улирлын байдлаар халамжийн тэтгэвэр 120 иргэн 133,281,450 төгрөг, асаргааны мөнгөн тэтгэмжийг 77 иргэн 39,185,530 төгрөг, онцгой байдлын мөнгөн тэтгэмжийг 55 иргэн 25,778,760 төгрөг, 1-р одонгийн мөнгийг 123 эх 24,600,000 төгрөг, 2-р одонгийн мөнгийг 300 эх 30,000,000 төгрөг, одонгийн дагалдах мөнгийг 7 иргэн 140,000 төгрөг, жирэмсэн эхийн мөнгийг 180 иргэн 41,816,830 төгрөг, ахмад настны тусламж хөнгөлөлтөнд 123 ахмад 153,238,825 төгрөг, ахмад настны хүндэтгэлд 155 ахмадад 1,550,000 төгрөг, насны хишгийг мөнгийг 199 ахмад 32,800,000 төгрөг, алдар цолтон 3 иргэн 4,490,000 төгрөг, ХБИ-ний тусламж хөнгөлөлтөнд 6 иргэн 983,030 төгрөг, ХБИ-ний протез ортопедын хөнгөлөлтөнд 19 иргэнд 3,765,000 төгрөгийг зарцуулсан байна.

### **Орхонтуул сум:**

Тайлант сард сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Засаг даргын нэрэмжит үзлэгийг төр, төсвийн байгууллагуудад зохион байгуулах зорилтын хэрэгжилтийг хангаж, Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг удирдамжийн дагуу 11-р сарын 20-нд сумын Эрүүл мэндийн төв, Соёлын төв, 24-р цэцэрлэг дээр ажиллаж бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, албан хэрэг хөтлөлт, удирдлагын тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл зэргийг хянаж, заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлж сумын Засаг даргын “Сахилга дэг журмыг чангатгах тухай” А/139 тоот захирамжийг гарган төр, төсвийн байгууллагуудад хүргүүллээ.

Сумын Онцгой комисс 11-р сарын 22-ны өдөр хуралдаж Мандал суманд малын гоц халдварт Шүлхий өвчин гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх ажлын эрчимжүүлж, малчидтай холбоо тогтоон өдөр бүр малдаа үзлэг тандалт хийлгүүлэх, сумын хилийн зааг орчмоор хөдөлгөөнт эргүүл ажиллуулж отор нүүдлээр мал оруулахгүй байх талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах талаар сумын Засаг даргын А/145 тоот захирамж гарган ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд малчдаас бэлчээр, өвөлжөөний газартай холбоотой гомдол санал сумын Засаг даргын Тамгын газарт ихээр ирж байгаа тул ММСС-н ХОБТ-д хамрагдсан Хонгор-Овоо 3-р багийн Малчдын бүлгүүдийг үйл ажиллагааг дүгнэх ажлыг тайлант сард зохион байгууллаа. Тус төслийн хүрээнд Хонгор-Овоо 3-р багийн малчдыг 18 бүлэг болгон хувааж бэлчээр эзэмшүүлсэнээс шалтгаалан бэлчээр, өвөлжөөний газартай холбоотой гомдол ихсэж бүлгүүд гэрээний дагуу малаа эрчимжүүлсэн болон төслийн санхүүжилтыг буцааж төлж байгаа эсэхийг дүгнэж, гэрээний заалтыг биелүүлээгүй бүлгийн гэрээг цуцлар хүртэл арга хэмжээ авах

зорилгоор Засаг даргын орлогч болон Хонгор-Овоо 3-р багийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн тасгийн даргын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллалаа.

Мерси кор олон улсын байгууллага, Онцгой байдлын газар хамтарсан “Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь-2” төслийн хүрээнд хийгдэж байгаа “Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандартууд” сургалт 2 өдөр явагдлаа.

Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор Засаг даргын орлогчоор ахлуулсан Ажлын хэсэг томилон хүнсний 8 нэрийн дэлгүүр, хүнсний мухлагуудад хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтанд Шар-Ус 1-р баг, Рашаант тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр-2, мухлаг-3 хамрагдсанаас хадгалах хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн зарж байсан нийтлэг зөрчил илэрсэн тул Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлагатай тооцохоор шийдвэрлэж зөвлөмж хүргүүлээ.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийн хүрээнд “Авлига үгүй чухал” сарын аян зохион байгууллаа. Аяны хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилж төрийн албан албан хаагчдын дунд Гар бөмбөгийн тэмцээн зохион байгууллаа. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 8 төсвийн байгууллагын 160 гаруй төрийн албан хаагчид ажиллаж байгаагаас тус тэмцээнд эрэгтэй 3, эмэгтэй 7 багийн 60 гаруй албан хаагч оролцож эрэгтэй төрөлд 1-р байрт Засаг даргын Тамгын газар, 2-р байрт Ерөнхий боловсролын 1-р сургууль, эмэгтэй төрөлд 1-р байрт Ерөнхий боловсролын 2-р сургууль, 2-р байрт Ерөнхий боловсролын 1-р сургуулийн баг шалгарлаа. Тэмцээнийн 1-р байр тус бүрийг өргөмжлөл 100,000 төгрөг, 2-р байрыг 80,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд насанд хүрээгүй иргэн холбогдсон гэмт хэргийн гаралтыг бууруулах эцэг, эхчүүдэд санамж мэдээлэл өгөх зорилгоор үүрэн холбооны Скайтелын сүлжээг хэрэглэгч тус сумын 619 иргэнд “Tani huuhed haana, hentei nuhurluj yawna. Huuheddee tavih haraa hyanaltaa saijruulj gemt hergees uridchilan sergilstgeey. Selenge, Orhontuul GHUSAZSZuvlul” гэсэн масс мессежийг илгээлээ. Маас мессеж үйлчилгээний зардалд 13849 төгрөг зарцуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн зардлаас зарцууллаа.

Тайлант сард иргэдээс нийт 9 өргөдөл ирсэнээс ажил хүссэн-5, мөнгөн тусламж хүссэн-2, өвөлжөөний газар хүссэн-1, ургамал түүх зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай-1 ирсэнийг мөнгөн тусламж хүссэн Хэсгийн цагдаа Ц.Цогтбаатарт Засаг даргын нөөц хөрөнгөөс 160,000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Энэ сард шинэ төрөлт 4, нас баралт 2 бүртгэгдэж, шилжиж ирсэн 18, шилжиж явсан 19 иргэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлж шинэ төрсөн 2 хүүхэд гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүллээ.

11-р сарын 23-н 16 нас хүрч шинээр цахим үнэмлэх авч байгаа 15 хүүхэд “Иргэний Андгай өргөх” ёслолын ажлын Ерөнхий боловсролын 1-р сургууль, Соёлын төвтэй хамтран зохион байгууллаа.

Нийгмийн халамжийн сангийн 11-р сарын халамжийн тэтгэвэрийг 41 хүнд 6090000 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 20 хүнд 1543200 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 23 эхэд 900000 төгрөг, Алдар цолтны тусламжийг 4 хүнд 1240000 төгрөг тус тус олгосон байна.

Халамжийн өндөр насны тэтгэвэрт шилжиж ирсэн 1 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт шинээр 1 иргэн, Байнгын асаргаа шаардлагатай ахмад настны тэтгэмжид шинээр 1 иргэнийг тус тус хамруулж тэтгэвэр, тэтгэмжийг олголоо. Ихэр хүүхэд төрүүлсэн 1 эхийн материал хүлээн авч хувийн хэрэг нээж аймагт явуулснаар 2000000 төгрөгийг олголоо. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хүрээнд 1 ахмад настанд шүдний хөнгөлөлт 65000 төгрөг үзүүлсэн байна. Жирэмсэн эхийн тэтгэмжид шинээр 8 эхийг бүртгэж, хувийн хэрэг нээн аймагт явуулснаар тэтгэмжийг олгуулж, амаржсан 1 эхийн сунгалтыг хийж явууллаа.



Сумын Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/117 тоот захирамжийн дагуу зохих зөвшөөрөлгүй хууль бусаар өвөлжөө барьсан 35 иргэнд хяналт шалгалт хийж улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлж зөрчлөө арилгаагүй 16 иргэний 18 өвөлжөөг албадан буулгаж бэлчээр, чөлөөлүүлсэн байна. Энэхүү ажлын хүрээнд албадан буулгасан өвөлжөөгөө өөрсдөө аваагүй зөрчлийг тухайн үед арилгаагүй 2 иргэнд тус бүр 1000000 төгрөгийн торгууль ногдуулж арга хэмжээ авсан байна.

Зохих зөвшөөрөлгүй хууль бусаар гэрээ байгуулахгүй газар ашиглан хадлан бэлтгэсэн зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 500000 төгрөгийн шийтгэл ногдуулаад байна.

Сэлэнгэ аймгийн Мандал суманд малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан сумын Онцгой комисс хуралдан урьдчилан сэргийлэх талаар дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

Тус сумын хилийн зааг болох Сэлэнгэ аймгийн Орхон сум, Төв аймгийн Жаргалант, Цээл, Заамар зэрэг сумдын хилийн дагуу нутаглаж буй малчидтай газар дээр нь уулзаж малд нэг бүрчлэн үзлэг тандалтын ажил зохион байгуулан заавар зөвлөмжийг өгч ажиллалаа.

Сумын хилийн зааг нутгаар нутаглаж буй малчин өрхүүдийг хөдөлгөөнт морин эргүүлээр томилж сэжигтэй тохиолдол илрэх, өөр аймаг сумын нутгаас туувраар мал оторлон орж ирэх зэрэг байдалд хяналт тавьж ажиллах талаар үүрэг даалгаврыг өгсөн байна.

### **Баруунбүрэн сум:**

Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын талаар гарсан төр засгийн хууль, тогтоомж, заавар зөвлөмж, дүрэм журам, Тамхины тухай хуулиар гарын авлага материал бэлтгэн худалдаа үйлчилгээ эрхэлж буй дэлгүүр, цайны газар, сургууль, цэцэрлэгийн гал тогооны тогооч, ажилчдад тараан сурталчилж, суманд үйл ажиллагаа явуулж буй дэлгүүр, цайны газруудад ажлын хэсэг хяналт шалгалт хийж, худалдагчийн халаад, малгай өмсөж хэвшээгүй, мах, сүү, өндөг, хиамны тамга тэмдэггүй шинжилгээний бичигтэй, эрүүл мэндийн үзлэгт дутуу хамрагдсан, мэргэжлийн үнэмлэхгүй, гурван дамжилгат угаалга хийдэггүй, гарын угаалтуур байхгүй, мэдээллийн самбар нь жижиг, хоол бэлтгэлийн өрөө бохир зэрэг зөрчил дутагдал илэрснийг цаг тухай бүрт нь хугацаатай шаардлага өгч дахин шалган зөрчил дутагдалыг арилгуулсан. Мөн хугацаа хэтэрсэн бараа бүтээгдэхүүнийг комиссын бүрэлдэхүүн болон дэлгүүрийн эзнийг байлцуулан устгал хийж, тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж баталгаажуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан хүлэмжийн аж ахуй эрхлэх, хүлэмжинд гүзээлзгэнэ тариалах арга технологи сэдэвт сургалтанд сумын 10 ногоочинг хамруулж, компани, аж ахуй нэгжүүдэд 2017 онд улаанбуудай тушаасан аж ахуй нэгж, иргэдийн урамшууллын материалыг аймгийн нэгтгэн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлээд байна.

Сумын Засаг даргатай байгуулсан 02 тоот гэрээний дагуу орон нутгаас байгалийн ховор ургамал болох Дэрвэгэр жиргэрүүг бэлтгэгч “Экопетролиум” ХХК-ий орон нутаг дахь бэлтгэн нийлүүлэгч иргэн З.Батцэцэг нь зөвшөөрөлгүйгээр тээвэрлэлт хийсэн зөрчил гарч Баянгол суманд саатуулагдан, шалгагдаж Мандал сум дахь сум дундын прокурорын газраас холбогдох материалыг харъяаллын дагуу шилжүүлснийг хүлээн авч холбогдох журмын дагуу шийдвэрлэж зөрчил гаргасан аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 1000000 /нэг сая/ төгрөгийн торгуулийн арга хэмжээг ногдуулсан. Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн албан тоотын дагуу Ойн санг гэрээгээр эзэмшигч иргэдийн нөхөрлөлүүдийн менежмент төлөвлөгөөний хэрэгжилт, тухайн жилд хийсэн ажлын тайланг гаргуулан, 2018 онд сумын ойн сангаас бэлтгэгдэх мод бэлтгэлийн талбайг сонгож сумын ИТХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг зохион байгуулж өгөгдсөн заавар журмын дагуу судалгааг гарган хүргүүлээд байна. “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлыг хамгаалах, ойн тогтвортой менежмент, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх” төслөөс нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж нэг нөхөрлөлд 5 га талбайд арчилгааны ажил хийх санхүүжилт өгсөн. Энэ ажлын дагуу ойн анги нь Баруунбүрэн сум, Сант сумын Хан хушаат, Алтансүмбэр, Ноёны бууц гэсэн төсөлд хамрагдсан 3 нөхөрлөлд арчилгааны ажлаар 5 га талбайд талбай тусгаарлалтын ажлыг хийж, БОАЖЯ, ОСХТ-өөс нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд Сант сумын 4 нөхөрлөлд цэвэрлэгээний ажил хийгдсэний дагуу талбайд хяналт тавьж нөхөрлөлийн ахлагч гишүүдтэй уулзалт хийлээ. Мөн МУИС-аас зохион байгуулагдсан ой хөнөөлт шавж, өвчин болон ой хамгааллын талаар мэргэжил дээшлүүлэх 2 өдрийн сургалтанд Хөвсгөл аймгийн ойн анги, Орхон аймгийн Баян-Өндөр суман дахь сум дундын ойн анги, Сэлэнгэ аймгийн Бугант Тосгоны мод үржүүлгийн газар, Орхоны бүсийн сум дундын ойн ангиас 9 хүн сургалтанд хамрагдсан.

FAO-н төслөөс Дархан хотод зохион байгуулагдсан бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл хөтөлбөр сургалтанд Дархан-уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Сант, Баруунбүрэн сумын нийт 15 нөхөрлөлийн ахлагч, гишүүд оролцсоноос гадна аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зохион байгуулсан сумын болон сум дундын ойн ангиуд, БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч, Ойн нөхөрлөлийн гишүүдийг мэдээллээр хангах үйл ажиллагааг идэвхижүүлэх сургалтанд байгаль хамгаалагч, ойн нөхөрлөлийн гишүүд, ойн анги хамтран оролцсон.

Сумын төвийн барилга байгууламжийн судалгаа, гүний худаг, усан сан, цэвэрлэх байгууламжийн судалгаа, сумын бэлчээрийн фото мониторингийн ажлын тайланг хүргүүлсэн.

2017 оны 11 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 80170.6 мянган төгрөгийн төлөвлөгөөгөөс гүйцэтгэлээр 102839.2 мянган төгрөг орж биелэлт 128.3 хувийн биелэлттэй, туслах үйл ажиллагааны орлого болон үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 34245.2 мянган төгрөг орохоос гүйцэтгэлээр 30212.9 мянган төгрөг орж биелэлт 88.2 хувьтай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт төсвөөс санхүүжих нь төлөвлөгөөгөөр 83616.0 мянган төгрөг ирэхээс гүйцэтгэлээр 79396.5 мянган төгрөгийн санхүүжилт ирж, зарцуулалт 67074.8 мянган төгрөг байна. Мал эмнэлэгийн үйлчилгээний санхүүжилт 25986.0 мянган төгрөг ирж 3 мал эмнэлэгийн вакциныг хариуцсан багийн малчдаар явж хийх зардалд 15664.5 мянган төгрөгийн зардлыг гаргаад байна.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төвөөс амбулаторийн үзлэг 215, урьдчилан сэргийлэх үзлэг 85, осол гэмтлийн өвчлөл 3, эмнэлэгт хэвтсэн 22, шээс, цус, цагаан хорхой, дох бэлгийн зам зэрэг шинжилгээнд 88 хүн хамрагдаж, жирэмсний хяналтанд байгаа 44 эх байна. 2017 оны 11-р сарын 03-нд Соёлын төвд сумын ард иргэдэд артерийн даралт, чихрийн шижин, өндөр, жинг үзэж биеийн жингийн индекс тодорхойлсон ба нийт 32 хүн хамрагдсан байна.

Мөн улсын хэмжээнд жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын хүрээнд 1 сарын аяныг 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж, сумын ЗДТГ-ын мэргэжилтэн, ажилтнууд, Д.Мягмарын нэрэмжит ЕБС-ийн багш ажилчид, сурагчид, 25-р цэцэрлэгийн багш ажилчид, хүүхдүүд, ЭМТ-ийн эмч, сувилагч, ажилчид, ард иргэдээс нийт 500 гаруй хүмүүс мөн 25-р цэцэрлэгийн 3-5 насны нийт 60 гаруй хүүхдүүдийг хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамруулах ажлыг зохион байгууллаа.

МУБИС-ийн сургалтын албаны баг хамт олон “Сургуулийн хөгжлийн хөтөлбөр” сургалтын агуулгын хүрээнд:

- Багшийн ёс
- Хүүхдийн сэтгэл зүйн онцлог

- Сургуулийн өмнөх боловсролын сэтгэл зүйн онцлог зэрэг сэдвүүдээр сургалт зохион явуулахад нийт 28-н багш хамрагдлаа.

Энэ хичээлийн жилд Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 38 дугаар тоот тогтоолын дагуу “Сэлэнгэ нутгаа алдаршуулах” түүх соёлыг таниулах зорилгын хүрээнд тус сургуулийн 1-12-р ангийн 506 суралцагчид “Сэлэнгэ минь” шүлгийг чээжлүүлэн уран тодоор уншах аянд сургуулийн сурагчид анги хамт олноороо идэвхтэй оролцлоо.

Сургуулийн намар цагийн соёл хүмүүжлийн ажлын нээлтийн үеэр “Хөдөлмөр, соёлын чуулган”-ыг 1-5-р анги, 6-12-р ангийн төрлөөр зохион явууллаа. Үүнд:

Бага ангийн төрөлд:

- 1-р байрыг Т.Мөнгөндолгио багштай 2б ангийн хамт олон
- 2-р байрыг Ж.Отгон-Эрдэнэ багштай 5б ангийн хамт олон
- 3-р байрыг Ж.Цолмон багштай 4а ангийн хамт олон

Дунд, Ахлах ангийн төрөлд:

- 1-р байрыг Э.Одонтунгалаг багштай 8б ангийн хамт олон
- 2-р байрыг Б.Энхмаа багштай 8а ангийн хамт олон
- 3-р байрыг Н.Хишигцацрал багштай 10а ангийн хамт олон тус тус шалгарч батламж, сургуулийн спорт зааланд тоглох эрхийн бичгээр шагнаж урамшууллаа.

Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг 2017 оны 11-р сарын 17, 18-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сургуулийн 10а, 11а, 12а ангиудын нийт 60 гаруй суралцагч, анги удирдсан багш нарт сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар сумын хурлын үйл ажиллагааны явц, бүтэц зэргийг тайлбарлан хэлж, санал асуулгын хүрээнд зохион байгууллаа.

Сургуулийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран “Цахим орчинд соёлтой оролцоё” сургалтыг зохион явуулахад 8а, 8б, 9а, 9б, 11а ангиудын нийт 85 суралцагч болон эцэг эхийн төлөөллийг хамрууллаа.

Хүүхэд хамгааллын ажлын хүрээнд тус сургууль нь хүүхэд хамгааллын хамтарсан багийн хурлыг 2 удаа хийж 4 хүүхдийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

- Хөдөөгийн алслагдмал багт амьдардаг 1 сурагч сумын төвд амьдрах айлгүй тул дотуур байранд оруулсан,
- Тус сургуулийн 2 сурагч архины хамааралтай эцэг эхтэй тул эцэг эхтэй нь уулзаж ганцаарчилсан зөвлөгөө өгсөн,
- Мөн хөдөө мал дээр амьдардаг 1 сурагчийг эцэг эх нь олон хоногоор хичээлд суулгахгүй байнгын таслуулж сурах нөхцлөөр хангахгүй байсан тул түүний гэрээр очиж холбогдох арга хэмжээг авч мэдэгдэл өгч хуулийн зөвлөгөө мэдээлэл болох “Боловсролын тухай хуулийн 46.2.1, 46.2.2, 46.2.3, 46.2.5”, дахь заалт “Зөрчлийн тухай хуулийн 9.1.4 дахь заалтууд”-ыг уншиж танилцуулан эцэг эхэд нь зөвлөгөө өгч ажиллаа.

Сургуулийн дотуур байрны 6-12-р ангийн сурагчдын дунд хурал хийж дотуур байрны дэг журам, сахилга хариуцлагын талаар яриа таниулга хийж, дотуур байранд хичээллэж байгаа дугуйлангуудад хамрагдаж буй сурагчдын судалгааг авлаа.

Энэ сард СӨБ-ын хүүхэд өдрийн төлөвлөгөө 159 хүүхэд авахаас 129 хүүхэд ирж хүүхдийн ирц 88%-тай биелэлээ. Хүүхэд хөгжүүлэх төлөвлөгөөг 14 хоногоор төлөвлөн, ажиглалт хийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж багш нар бүлгийн хүүхдүүдийн дэлгэрэнгүй бүртгэл хийж нэгтгэх ажлыг зохион байгууллаа. Мөн нарийвчилсан бүтэцтэй ажиглалт болон локол праграмм хөтлөх талаар ярилцан үйл ажиллагаагаа явуулж байна.

Сант суманд болсон Баруун бүсийн “Ахмадын тэмцээн”-д сумын баг тамирчид амжилттай оролцон баг хамт олноороо 1 дүгээр байр эзэллээ.

Аж ахуйн эрхлэлтийн анхан шатны мэргэшүүлэх “Бизнесээ эхэл” хөтөлбөрийн хүрээнд зохион явуулсан сургалтанд сумын нийт 20 иргэнийг хамрууллаа.

Шинээр бий болсон 25 ажлын байрны бүртгэлийг ШАБ, ХЗЗ маягтын дагуу бүртгэн мэдээллийн санд оруулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан

багийн тайланг Сэлэнгэ аймаг Хүүхэд гэр бүл хөгжлийн газарт хүргүүлж, Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, үр дүнг тооцох хамтарсан багийн бүрэлдэхүүн хуралдаж Хүүхэд хамгаалалын 108 утсанд ирүүлсэн мэдээллийн дагуу ажиллаж гэр бүлийг эвлэрүүлэн зуучлах арга хэмжээ авлаа.

### **Шаамар сум:**

Сумын төвөөс алслагдан амьдарч байгаа айл өрхүүдийн өвөлжилтийн бэлтгэл байдалтай танилцаж эмч, эмийн үйлчилгээг 1,2 дугаар багийн хэмжээнд зохион байгуулсан. Дэлгэрхаан 1 дүгээр багийн Дэнжийн гүний худгийн байрны дулаалга засвар үйлчилгээг хийж, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах малын үүлдвэр угсаа, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор суманд ирсэн “Хар ангус” үүлдрийн 4 буханд үзлэг хийж, бух хүлээлцэх актаар Охиндий 2 дугаар багийн “Өсөх-эрдэнэ” сүргийн эмч, Дэлгэрхаан 1 дугаар багийн малчин Ө.Сүхбат, Д.Ганхуяг, Дулаанхаан 3 дугаар багийн малчин М.Мөнхтөр нарт хүлээлгэн өглөө.

Мандал суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч нар хариуцсан багийн малд үзлэг тандалт хийж, шүлхий өвчний талаарх гарын авлага тараасан. Мөн тус сумын нутаг дэвсгэр дээр зөвшөөрөлгүй буусан Дархан уул аймгийн харъяат малчин Х.Ганбаатарыг сумын Засаг даргын 2017 оны А/114 тоот захирамжаар албадан нүүлгэх ажлыг зохион байгуулсан.

Ургац хураалтын эцсийн мэдээг 6 аж ахуйн нэгж, 476 иргэнээс авч нэгтгэж аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар хүргүүлсэн. Сумын дүнгээр үр тариа 1971 га-гаас 1779,3 тн, Рапс -840 га-гаас 597,7 тн, төмс 90, 42 га-гаас 1012 тн, хүнсний ногоо 195,3 га-гаас 2504,5 тн ургац хурааж авч, дараа оны тариалалтанд зориулж 115 тн улаан буудайг нөөцөлсөн.

БОАЖЯ-ны ОХСТөв болон МХЕГ-ын даргын баталсан хамтарсан хяналт шалгалтын 02/269 тоот удирдамжийн дагуу 11 дүгээр сарын 21-ээс 25-ны өдрүүдэд аймгийн ой бүхий 7 сум 1 тосгонд хууль бус мод бэлтгэл, ойжуулалт нөхөн сэргээлт ашиглалт болон Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд Ойн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм журмын хэрэгжилтийн талаар шалгаж шалгалтын талаар танилцуулгыг ажлын хэсгийн ахлагчид гаргаж өгсөн. Хяналт шалгалтаар улсын байцаагчийн 8 албан шаардлага, 1 зөвлөмжийг үйлдэж холбогдох сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, СДОАнгид өгч танилцуулж хариуг тогтоосон хугацаанд гаргаж өгөхийг шаардсан. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашигт малтмалын олборлолтонд хяналт тавьснаар сумын хэмжээнд 9,767,000 төгрөгийн орлого төвлөрсөн байна. Орхон голын гүүр орчимд Цагдаагийн алба хаагч болон Байгаль хамгаалагчийн хамтаар өдөр болон шөнийн цагаар нийт 4 удаа хийсэн. Эргүүл хяналт шалгалтанд 19 иргэн, 12 тээврийн хэрэгсэл хамрагдсан. Мөн зорчиж буй иргэдэд голын мөс бүрэн гүйцэд хөлдөөгүй байгаа ба голын мөс цөмөрч аюул осол гарах эрсдэл ихтэй тул зориулалтын зам гүүрээр зорчиж байхыг сануулсан.

Газрын тухай хуулийн 38.1.1 –р заалтын дагуу газар эзэмших эрхээ шилжүүлэх хүсэлт гаргасан 6 иргэний хүсэлтийг хүлээн авч газар эзэмших эрхийг шилжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 28 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авснаас өмчлөх 19, эзэмших 1, эрх шилжүүлэх 6, хамтран өмчлөгч хасагдах 2 иргэний өргөдлийг бүртгэн авч өргөдөл хүсэлтийн улсын бүртгэлд бүртгэв. Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах хүсэлт гаргасан 2 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцааны бүртгэлд бүртгэлд бүртгэж орон нутгийн тэмдэгтийн хураамжинд 30000 мянган төгрөгийг оруулав.

Нийгмийн даатгалын сангийн тайлан тэнцэлээр 2017 оны 11-р сарын 27-ны байдлаар 23 ажил олгогч 199 даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж сайн

дурын даатгалд шинээр 3 хүн хамруулж нийт 215 даатгуулагчийн шимтгэлийг сар болон улирлаар төлүүлж нийгмийн даатгалын дэвтэр болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрийг тухай бүр нь баталгаажуулсан. Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмжид 2 хүнд 2,0 сая төгрөг, 6 хүнд ажилгүйдлийн тэтгэмж 2600,0 мянган төгрөг тус тус олгосон.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах 25 өргөдөл хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шаардлагатай материалуудыг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж дээд шатны байгууллагад уламжлан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид хамрууллаа.

Ахмад настангуудад ахмад настны шинэчилсэн хуулиар хуулийн сургалт зохион байгууллаа. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй байсан шинээр төрсөн 26 хүүхдийн холбогдох бичиг баримтуудыг Сэлэнгэ аймгийн НХҮГазарт хүргүүлэв.

"Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ"-ний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 6 өрхийн 33 гишүүнд 2017 оны 10 дүгээр сарын талон болох 46 ширхэг үнэт цаас бүхий 299000 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ийн "Шонхлой" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

2017 оны 11 дүгээр сарын байдлаар Шаамар сумын 1,2 дугаар багийн хэмжээнд шинээр төрсөн эрэгтэй-1, эмэгтэй-2 хүүхэд төрж нийт 3 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгосон. Нас барсны 1 гэрчилгээг иргэдийн хүсэдтийн дагуу олгосон. "Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах журам"-ын дагуу энэ сард иргэний үнэмлэх шинээр авах -4, 25,45 насны сунгалт хийлгэх 9 иргэний хүсэлтийг үндэслэн /ИУБ-31/-ыг цаасан болон цахим хэлбэрээр CD-нд хуулбарлан баталгаажилтанд өгсөн. Иргэний үнэмлэхээ дахин авах хүсэлт гаргасан 5 иргэний материалыг бүрдүүлсэн.

Хэвлэгдэн ирсэн 31 иргэний үнэмлэхийг иргэдэд тарааж ИУБ-21 бөглөн холбогдох газарт хүргүүлсэн. 11 сарын байдлаар Улаанбаатарлуу шилжсэн-2, бусад аймаг руу шилжсэн-7, баг хооронд шилжсэн-4 иргэн нийт 13 иргэнийг хүсэлтийн дагуу шилжүүлсэн. Бусад аймгаас шилжин ирсэн 7 иргэнийг хүсэлтийн дагуу бүртгэл хийж хүлээн авсан. Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настангуудад сургалтын зохион байгуулсан. Сумын орон нутгийн орлогод 85400 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

2017 оны 10 сарын 29-нд аймгийн төвд болсон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан Монголын уламжлалт үндэсний спортын "Монгол наадгай" үндэсний уламжлалт тэмцээнд 5 хүн авч явснаас шагай шүүрэх тэмцээнд Б. Нэргүй хүрэл медаль, шагай няслах тэмцээнд С. Ширнэн мөнгөн медаль хүртсэн амжилттай ирлээ. Сумын ИТХ-аас 2017.11.18-нд зохион байгуулсан Шаамар сумын "Сумын аврага" шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулж, шатрын тэмцээнд 7 тамирчин оролцсноос тэргүүн байранд Б. Дансран, дэд байранд Г. Бадамцэрэн, гутгаар байранд Б. Мягмар тус тус орлоо.

"Баясагалант ирээдүй" 2-р цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд холимог гар бөмбөгийн тэмцээнийг 11-р сарын 23-ны өдөр зохион байгуулж, 1-р байранд ахлах бүлэг, 2-р байранд бага бүлэг, 3-р байранд дунд бүлэг тус тус шалгарсан.

ТЕГ-ын даргын 2017 оны 10-р сарын 30-ны өдрийн А/190 тоот тушаалын дагуу Хуулийн этгээд, Хувь хүний тооллогыг 11-р сарын 24-ний өдрөөр дуусгаж ААН-113, хувь хүн -23, нийт-136 хуулийн этгээдийг тооллогод хамруулсан.

Аймаг улсын төвлөрсөн төсөвт 6534071,80 сая төгрөг, сумын төсөвт 541300 мянган төгрөг нийт- 7075371,8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажилласан.

### **Сүхбаатар сум**

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газрын ажил хэргийн хурлыг 4 удаа зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот "Сахилга

хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврыг танилцуулсан. “Гэр бүлийн хүчирхийллийг тэг болгоё” аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй, өртөж буй иргэдийг хамруулан шилдэг илтгэгч А.Отгонбаатар, сэтгэл судлаач Г.Цэнд-Аюуш нарын илтгэлийг 8 багийн 250 гаруй иргэнийг хамруулан зохион байгууллаа.

Сумын “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 7 багийн 60 гаруй малчин, мал бүхий иргэд хамрагдаж тулгамдаж буй асуудал, хадлан тэжээл, бэлчээр, мал эмнэлгийн үйлчилгээний талаар санал бодлоо солилцож, мэдээ мэдээлэл өгсөн. Энэ үеэр өрхүүдийн эрүүл мэндийн төвөөс чихрийн шижин эрт илрүүлгийн сорил, артерийн даралт, биеийн жин, өндрийг үзэж, урьдчилан сэргийлэх үзлэгт малчдыг хамруулсан.

2017-2018 оны өвөл судалгаагаар сумын хэмжээнд 119 малчин өрхөд 395 иргэн, 6809 толгой мал өвөлжих бөгөөд, мал бүхий иргэдийн хадлан тэжээл бэлтгэлийн судалгааг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн. Энэ онд малчин, мал бүхий иргэд 3900 тн байгалийн хадлан, 3 тонн дарш, 7,5 тн будаа, 12 тонн үр тарианы хаягдал, 3,5 тн хивэг, 1 тонн хужир бэлтгэсэн байна. Аймгийн Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газраас өгсөн чиглэлийн дагуу шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, зөвлөмж сэрэмжлүүлгийг малчдад хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах арга зүй” сэдэвт сургалтанд сумын 20 ногоочин хамрагдаж, өвлийн хүлэмж барих арга, хүлэмжинд жимс, хүнсний ногоо тариалах технологи, хүнсний ногооны өвчин хортонтой тэмцэх арга, үр үржүүлэх боломж, ногооны үрслэг бойжуулах, ургалтын арчилгааны талаар мэдээлэл авсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Цэвэр сайхан орчин” арга хэмжээний хүрээнд сум, багийн нутаг дэвсгэрт байгуулах аж ахуйн нэгж, 100 гаруй өрх бүх нийтийн цэвэрлэгээнд оролцсон.

### **Жавхлант сүм:**

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөл 2 удаа, байгууллагын өргөтгөсөн шуурхай хурал 3, албан хаагчдын хурал 1 удаа хуралдаж, сумын Засаг даргын А/143 тоот захирамжаар байгуулагдсан Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт, зөвлөн туслах ажлын хэсгээс сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвийн үйл ажиллагаатай танилцан үзлэг шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ. Үзлэг шалгалтын үеэр байгууллагуудын албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандарт, тайлан төлөвлөгөө, дотоод журмын шинэчлэлт, хөдөлмөрийн гэрээ, өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байдал, эцэг эхчүүд, багш ажилчдаас санал асуулга авах, ТАХ-даас хуулийн мэдлэг шалгах шалгалт авах, мэдээ мэдээллийн ил тод байдлыг шалгах, дотоод хяналт, ёс зүйн хорооны үйл ажиллагаа, Санхүүгийн бүртгэл хөтлөлт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалтай танилцах, галын булангийн иж бүрдэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгууллагын нэг өдрийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж гарсан алдаа дутагдал, илэрсэн зөрчлийн талаар газар дээр зөвлөн туслаж зөвлөгөө өгч ажиллалаа.

Нутгийн удирдлагын байгууллагын 25 жилийн ойг төлөвлөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлж үе үеийн Иргэдийн төлөөлөгчид цугларан “Дурсамж, сургамж, с° âë° ì æ” хэлэлцүүлэг, сайн үйлсийн аяныг зохион байгуулж 2 иргэнд түлээ нүүрсний мөнгө хандивлалаа.

Өвөл цагийн мэдээллийн цагийн нээлтийг төр төсвийн байгууллагуудын албан хаагчид, иргэдийн дунд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-иар сургалт зохион байгуулж нийт 36 албан хаагч, иргэд хамрагдлаа. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Төрийн албан хаагчид”-ын өдөрлөгийг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, байгууллагуудын дунд аян зарлаж албан хаагчдын дунд илтгэлийн уралдааныг 2 үе шаттай явуулж, гар бөмбөг, шатрын тэмцээн, баярын хурал, кафе үдэшлэг зэргийг зохион байгуулж шилдэг төрийн

албан хаагчдаа урашуулан шагналаа. Мөн төрийн захиргааны албан хаагчийн “Тангараг” өргөх арга хэмжээг зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 05 тоот албан даалгаврын дагуу ажлын хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган албан хаагч бүр иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд бухимдал, чирэгдэл учруулахгүйгээр соёлтой, шуурхай үйлчилж, төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай хангах үүрэг даалгаврыг өглөө.

Орон нутгийн татварын орлого 24150,0 мянган төгрөг орохоос 63950,2 мянган төгрөг орж 264,8 хувиар биелсэн.

Тайлант сард 53 иргэний бүртгэл хийгдсэнээс шинэ төрсөн 4, гэрлэлт бүртгүүлсэн 1, нас барсан 2, гадаад паспорт захиалах, сунгалт хийлгэсэн 2 цахим үнэмлэх захиалсан 11, иргэний үнэмлэх хэвлэгдсэн 17, иргэний үнэмлэх дахин авсан 3 иргэн байна. Шилжин явсан 5 иргэн, шилжин ирсэн 13 иргэний бүртгэл хийж үйлчиллээ.

Эрүүл мэндийн төвөөс 377 үндэслэлээр урьдчилан сэргийлэх үзлэг 134, агаарын тусламж 71, идэвхитэй хяналт 46, гүдгээг үзлэг 126 хийж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвөлгөө өгч, 34 өвчтөн эмчилж, 11 эх жирэмсэний хяналтад байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн 13 эмчийн бүрэлдэхүүнтэй тус суманд ажиллаж, халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, цогц үзлэг оношилогоог үнэ төлбөргүй явуулж, 15-аас дээш насны 1371 иргэн хамрагдахаас 888 иргэн хамрагдаж хамрагдалтын хувь 82,8 хувьтай байлаа. Энэ үеэр дэвшилтэт технологи зөөврийн дижитал рентген аппаратын нээлтийг зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас 11-р сард өндөр настан 220 тэтгэвэр авагчид 60100,3 мянган төгрөг, тахир дутуу 63 тэтгэвэр авагчид 16411,3 мянган төгрөг, тэжээгчээ алдсан 15 тэтгэвэр авагчид 3520,0 мянган төгрөг, цэргийн 3 тэтгэвэр авагчид 1422,3 мянган төгрөг, нийт 301 тэтгэвэр авагчид 81453,9 мянган төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн 1 тэтгэвэр авагчид 483,9 мянган төгрөгийн тэтгэвэрийг, ажилгүйдлийн даатгалын сангаас 2 даатгуулагчид 252,1 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгосон. Тэтгэмжийн даатгалын сангаас 2 даатгуулагчид 1673,5 мянган төгрөгийн жирэмсэн, амаржсаны тэтгэмж, 3 даатгуулагчид 159,26 мянган төгрөгийн ХЧТА-ны тэтгэмж, 2 даатгуулагчийн ар гэрт 2000,0 мянган төгрөгийн оршуулгын тэтгэмжийг олгов.

Дархан-Уул аймгийн жижиг дунд үйлдвэрийн газартай хамтран аж ахуй эрхлэх сургалтыг зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн дунд 3 өдөр зохион байгуулж 15 иргэнийг хамруулж, аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтран сантехникийн мэргэжил олгох сургалтыг “Монжим”ХХК-ний галч нарын дунд 5 өдөр зохион байгууллаа.

Сумын “Алтан намар-2017” ургацын баярыг газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн дэмжлэг тусалцаатайгаар амжилттай зохион байгуулж, тэргүүний шилдэг тариаланч, ногоочин, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан шагнаж урамшуулж, сумын аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллага, баг, ТББ, ногоочид, иргэдийн дунд гар бөмбөгийн тэмцээнийг зохион явууллаа. Энэхүү арга хэмжээнд боксын спортын мастер Т.Есүгэнд 500.000 төгрөг хандивлаж, “Жавхлантад үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Сумын иргэд, айл өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах үүднээс Моностой 2-р багийн нутаг дэвсгэр Цагаан даваанаас ойн цэвэрлэгээний зориулалтаар нийт 58 иргэнд түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг олгож гүйцэтгэлд нь хяналт тавин бэлтгүүлж, төр төсвийн байгууллагуудын уурын зуухнаас гарсан үнс нурам, хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт буулгасан.

2017-2018 онд сумын хэмжээнд хонин толгойд шилжүүлснээр 182230 толгой мал өвөлжихөөр байна. Өөрийн болон бусад аймагт отор нүүдэл хийж өвөлжих 1230 толгой мал, үүнээс бод 242, бог 993 байна. Сумын хэмжээнд шаардагдах хадлан

тэжээл 6411 тн хадлан авахаас 6372 тн хадлан бэлтгэж, шөвөг яр, дотрын халдварт хордлого, дуут, галзуу, боом, сохор доголын вакциныг бүх малд 100% хийж гүйцэтгэлээ.

### **Түшиг сүм:**

Жил болгон зохион явуулдаг “Ургац-2017” баярын арга хэмжээг зохион байгуулан, газар тариаланд ажиллаж байсан 2 өндөр настан мөн энэ онд ажилдаа амжилт гаргасан 4 тариаланчдыг шагнаж урамшуулсан байна.

Мөн иргэний “Андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг “Улс тунхагласаны баяр”-ыг хамтатган өргөн хүрээтэй зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн нийт 23 сурагч “Иргэний андгай” өргөж төрийн албан хаагчдын нийт байгууллагуудын 60 гаруй ажилтан албан хаагчид тангараг өргөлөө. Мөн албан хаагчдын дунд илтгэлийн тэмцээн болон хөгжөөнт тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Илтгэлийн тэмцээнд: ЕББДСургуулын Монгол хэл-Уран зохиолын багш Л.Атарцэцэг тэргүүн байр, СӨБ Мономхон 27-р цэцэрлэгийн багш М.Баянжаргал нар дэд байр эзэлж, хөгжөөнт тэмцээнд ЕББДСургуулийн баг 1-р байр, СӨБ Мономхон 27-р цэцэрлэгийн баг 2-р байрыг тус тус эзэллээ.

Орон нутгийн хөгжлийн сангаас Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд зориулан “УАЗ Поргон” авто машинтай болголоо.

2017 оны орон нутгийн орлого жилд 91,948,9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 71,073,2 мянган төгрөгийн орологыг төвлөрүүлж, 77,29%-ийн биелэлттэй байна.

Аймгийн "Ногоочдын зөвлөгөөн, хүлэмжинд гүзээлзгэнэ тариалах арга технологи" сэдвээр сургалт уулзалтанд сумаас 10 ногоочин, ХААТ-н дарга, Засаг дарга нар хамтарч амжилттай оролцсон. Улаан буудай тушаасан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн урамшууллын материалыг хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуйн газар хүргүүлэн ажилласан. Отор нүүдлээр орж ирсэн малчдын судалгааг гарган Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Аймгийн мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаатай танилцан мах, сүү, зөгийн бал хэрхэн шинжлэх талаар 2 хоног дагалдан ажилласан. Жил болгон уламжлал болгон зохион явуулдаг “Ургацын баяр” арга хэмжээг зохион байгуулж, газар тариаланд ажиллаж байсан 2 өндөр настан мөн энэ онд ажилдаа амжилт гаргасан 4 тариаланчдыг шагнаж урамшуулсан байна. Зүүнхараад шүлхийн сэжиг илэрсэнтэй холбоотойгоор малчин болон мал бүхий иргэддээ зөвлөмж сэрэмжлүүлгийг өгч байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх малын удам гарваль сайжруулах зорилгоор жил болгон явуулдаг малын үзлэг, ангилалтыг нийт 10 малчин өрхийн 500 толгой бод иалд үзлэг ангилалтыг хийгээд байна.

2017 онд 8 малчин өрх төслийн хуц гэрээгээр ашиглаж, Малчдын саналд тулгуурлан хээлтүүлэгч малыг малчин иргэнээр маллуулж тухайн иргэнийг малжуулах арга хэмжээ аван, хуц, ухна маллах иргэнийг Засаг даргын тамгын газрын дарга Б.Уранчимэгтэй гэрээ байгуулан, 102 малчин өрхийн 100 гаруй хуц, ухныг маллуулж байна.

Түшиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 117 тоот тогтоолын дагуу сумын 66 малчин өрхөд 8,044,820.00 төгрөгийн мэдэгдэх хуудас тараагаад байна. Иргэнд е-баримт олгохгүй байгаа 8 аж ахуйн нэгж, 3 иргэнд албан шаардлага хүргүүлснээр “Зоригт Алтай” ХХК, “Ургац Алтай” ХХК, ШТС, “Зэлтэрийн өгөөж” ХХК-ууд баримт олгож эхэлсэн байна. Шинээр 21 иргэнийг и-мэйл хаяг нээн и-баримтад бүртгүүлсэн

2017 оны 11 сарын байдлаар шинээр газар өмчлөх хүсэлтэй 10 иргэн, хуучин хашааны газраа өмчлөх хүсэлтэй 4 иргэн, өргөдөл ирүүлсэн 5 иргэний газар өмчлөх хүсэлтийг шийдвэрлэж, өвөлжөөний газар өмчлөх хүсэлтэй 4 өргөдлийн 1 өргөдлийг шийдвэрлэж, 3 иргэнд хариуг хүргүүлсэн. Уг 3 иргэний өргөдлийн хариу Гауар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй тул шийдвэрлэх боломжгүй байсан. Нийт өргөдлийн 70% шийдвэрлэлттэй байна. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх



тухай хуулийн дагуу 2 иргэнд 0.9 га буюу 6800 мянган төгрөгний үнэ бүхий газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүйгээр өмчлүүлсэн байна. Газар өмчлөгч 4 иргэний хувийн хэргийн бүрдүүлэлт, өвөлжөөний газар эзэмшиж авсан 6 иргэний хувтийн хэргийн бүрдүүлэлтийг хангаж ажилласан байна.

Тайлант хугацаанд шинээр төрсөн 2, овог нэр өөрчлөлт 1, эцэг тогтоолт 3, шинээр гэр бүл болсон 2, нас баралт 3, иргэний үнэмлэх олголт 30, иргэний үнэмлэх шинээр захиалсан 2, иргэний үнэмлэхний сунгалт хийсэн 4, иргэний үнэмлэх дахин захиалсан 4, шилжин явсан 7, шилжин ирсэн 11 иргэн бүртгэгдсэн.

### **Хушаат сум**

Халдварт өвчин судлалын Үндэсний төв, аймгийн эрүүл мэндийн газар, сумын эрүүл мэндийн төв хамтран "Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн цогц үзлэг"-ийг Хушаат суманд зохион байгуулж 30 гаруй эмч мэргэжилтэн ажиллаж 1020 иргэнийг үзлэгт хамрууллаа.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудыг сурталчлах арга хэмжээний хүрээнд төр төсвийн байгууллага, ТББ, багуудын дунд "Архи амьдралын дайсан" АСТ-ийг 4 дэх жилдээ сумын ЗДТГ-ын ТЗХЭЗ-н мэргэжилтэн, Соёлын төвийн номын санч, ЕБС-ийн НТБОТөвийн багш нар хамтран зохион байгуулж, тэмцээнийг багийн мэндчилгээ, архидан согтуурах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдэвтэй жүжигчилсэн тоглолт, хуулиудын асуулт хариулт, буухиа тэмцээн гэсэн төрлүүдээр явуулж сумын "Яргуй" цэцэрлэгийн "Тэмцэл" баг тэргүүлж Соёлын төвийн "Культура" баг, Д.Сэнгээгийн нэрэмжит ЕБСургуулийн "Авхаалж" багууд удааллаа. Тэмцээнийг ИТХ, Соёлын төв, ЕБСургууль, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй "Хөшөө чулуу", "Өсөх бүрэн хан" ХХК-иуд ивээн тэтгэлээ. Мөн "Зөрчлийн тухай хууль" "Архины хор уршиг" сургалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Зөрчлийн тухай хуулиудын гарын авлагыг тарааж иргэдэд сурталчиллаа.

Аймгийн Онцгой байдлын газартай хамтран Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг тус суманд 1 өдөр зохион байгууллаа.

Улс тунхагласны баярыг тохиолдуулан "Андгай өргөх ёслол"-ыг сумын Улсын бүртгэгч, ТЗХЭЗМэргэжилтэн нар зохион байгуулж 16 нас хүрч иргэний үнэмлэх авч байгаа 7 хүүхдэд иргэний үнэмлэхийг гардуулан Монгол улсын иргэний андгайг гардуулан өргүүлж төрийн далбаандаа хүндэтгэл үзүүллээ. Мөн "Зөрчлийн тухай хууль- Хүүхдийн эрх" " Зөрчлийн тухай хуулинд Улсын бүртгэл" сургалтуудыг зохион байгуулж 21 сурагч оролцлоо.

Ургац хураалтын эцсийн мэдээг ХАА-9 маягтаар таримлын төрлөөр нийт 28 ААН, 70 иргэн бүрээр гарган мэдээллээ. Улаанбуудайн урамшуулалд хамрагдах аж ахуйн нэгжүүдүүдэд материал бүрдүүлэх талаар мэдэгдэн орлогын албан татвар, нийгмийн даатгалын тооцоо хийх тойрох хуудас зуруулж материалыг бүрдүүлж тодорхойлолт гарган өгч, хаврын тариалалтанд зориулан ногоочдод хөнгөлөлттэй үнээр зээлээр олгосон шатахууны үлдэгдэл үнийг төлүүлэх ажлаар ААН, ногоочидтой харилцаж зээлийг төлүүлж дуусч байна. МҮОНТелевизийн Монголын мэдээ сувгийн мэдээний албанд сумын Засаг дарга, ХААТ-ийн дарга нар сумын газар тариалангийн салбарын түүх, өнөөгийн ололт амжилтын талаар ярилцлага өгч орон даяар мэдээлэгдлээ

Статистикийн мэдээллээр үр тариа хураасан талбай га-гаар 11285 га, хураасан ургац 18257 тн, хураасан төмсний талбай 131,3 га, хураасан ургац 3139 тн, хүнсний ногоо хураасан талбай 182,6 га, хураасан ургац 2516 тн байна. Сумын хэмжээнд өссөн дүнгээр 5761 мал хорогдсон байна. үүнээс адуу 38, үхэр 687, хонь 2993, ямаа 2043, хээлтэгч 2905 хорогдсон байна.

Малчин, мал бүхий иргэдийг "Мерси кор" ОУБ-ын бэлтгэн, хандивласан малын халдварт 7 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авалга, зудын эрсдлийг даван туулах зөвлөмжөөр хангалаа.Мөн Мандал суманд малын гоц

халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан сумын төвийн малчин мал бүхий иргэдийг цуглуулан уг өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл өгч гарын авлагаар хангалаа. Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн зөвлөмжийг малчин мал бүхий иргэдэд танилцуулж, Малын эмч нарт хүргүүллээ. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарыг идэвхгүй тандалтын аргыг ашиглан тандалт хийж мэдээллийг дээд байгууллагад мэдэгдэх, үйлчлүүлсэн малчид мал бүхий иргэдийг сэрэмжлүүлж, зөвлөгөө өгөх, гарын авлагаар ханган ажиллахыг зөвлөлөө.

2017 оны 11-р сарын 15 өдөр Сэлэнгэ аймгийн Хушаат суманд Сумын ЗДТГ болон КЦТ үүлдрийн үхэр үржүүлэгчдийн холбоо хамтран “Зөвлөлдөх уулзалт” зохион байгууллаа. Зөвлөлдөх уулзалтанд Сумын ЗД, КЦТ үүлдрийн үхэр үржүүлэгчдийн холбоо, “Сэлэнгэ геррефорд” ХХК, Мерси Кор ОУБ, “Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн зөвлөх баг мөн малчдын төлөөлөл оролцсон.

Төр төсвийн байгууллагуудыг архивыг цахимжуулах ажил болон албан хэрэг хөтлөлтийг цахимаар явуулах ажлын хүрээнд төсвийн 5 байгууллагаар сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг ажиллан архивын хадгалалт хамгаалалт, цахим архивын программ ашиглалтын түвшинг тогтоон сумын ЗДТГ, цэцэрлэг, ЭМТ зэрэг байгууллагад программ дахин суулгуулах, ажиллагсдын ачаалалыг тэнцүүлэн архивын ажлыг эрчимжүүлэх зэрэг үүрэг даалгавар өглөө.

Энэ сард улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрөлт 3, эцэг тогтоолт 1, шилжин явсны 8, шилжин ирсний 5, гэрлэлтийн 2, нас барсны 1, цахим үнэмлэх дахин авах 8, биеийн давхцахгүй өгөгдлийн 20, иргэний үнэмлэх олголтын 16 нийт 64 бүртгэл хийж 8 гэрчилгээ бичиж олгосон. Төрийн сан банкны орон нутгийн дансанд 31400, УБСГ-ын дансанд 425000 төгрөгийн орлого оруулсан байна.

Аймгийн санхүү хяналт аудитын албанаас 2016, 2017 оны санхүүгийн анхан шатны баримт, материал, бүртгэл хөтлөлтөнд хөндлөнгийн шалгалт хийсэн ба шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүрд нь залруулж ажиллалаа. Орон нутгийн татварын ба татварын бус орлогын төлөвлөгөө 48.948.9 мянган төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл нь 59.239.8 мянган төгрөг нийт гүйцэтгэлийн хувь нь 121% байна. Аймгийн ИТХ-аас төсвийн тодотголд өөрчлөлт оруулах тухай 33 тоот тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-аар төсвийг хэлэлцүүлж батлууллаа.

Төсөвт байгууллагуудын 10-р сарын санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг өссөн дүнгээр гарган мэдээллийн самбаруудад байрлууллаа. Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтын эрхийн баталгааг батлуулж ажиллаж байна. Төсөвт байгууллагуудын батлагдсан төсвийн хуваарилалтын дагуу зардлуудыг санхүүжүүлж үндсэн цалин, хангамж, бараа материал, байр ашиглалттай холбоотой зардлуудын гүйлгээг хийж ажилласан.

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгээс зохион байгуулсан "Мэргэжлийн нягтлан бодогчдын тангараг өргөх ёслол"-д сумын Санхүүгийн албаны бүх нягтлан бодогчдыг бүрэн хамруулж тангараг өргүүлэн ёс зүйн дүрмийг судлуулж ажилласан.

Сумын Цагдаагийн хэсэг нь энэ сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэргийн шинжтэй дуудлага мэдээлэл 2, зөрчлийн шинжтэй 1 дуудлага мэдээлэл хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэв. Эргүүл шалгалтыг 20 удаа 120 цаг хийж худалдаа үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавин худалдагч нарт цагийн хуваариар болон хуулийн хүрээнд ажиллах яриа таниулга хийлээ. Малын хулгайн 1 хэрэг гарсныг илрүүлэн эрүүгийн хэрэг үлүүсгэн шалгаж байна. Замын цагдаагийн тасагтай хамтран 11 зөрчил илрүүлсэн ба зохих зөвшөөрөлгүй бор гөрөөс, хур шувуу тээвэрлэж явсан 1 зөрчил, зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн 1, бичиг баримтгүй 1, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 1 зөрчлийг илрүүлэн 540.000 төгрөгийн торгууль тавилаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар гарын авлага зөвлөмж бэлтгэн олон нийтийн газар, гудамжуудаар тарааж сурталчлав. Хууль бус аргаар мод бэлтгэх

үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор Артойлбо, Ар сэвд Арсүүж, дэрвэдэг, Ногоон хунх зэрэг газруудаар эргүүл шалгалт хийлээ.

Нийгмийн даатгалын болон ЭМД-ын тухай хуулиудыг өссөн дүнгээр 648 хүнд сурталчилж тараах материал болон гарын авлагыг 568 хүнд тарааж ажиллажээ. НДШ-д 31 байгууллага, ААН-ийн 229260.0 мянган төгрөгний, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 123 хүний 25545.3 мянган төгрөгний шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 219 хүний 12790.1 мянган төгрөгний хураамжийг оруулжээ. Тэтгэвэр тогтоолгох 19 хүний, шилжин ирсэн 1, шилжин явсан 1, зогсогдсон 1 хүний материалыг бодож баталгаажуулжээ.

Д.Сэнгээгийн нэрэмжит ЕБС-ийн сурагчдын дунд танин мэдэхүйн чиглэлээр зохиогдсон "Аялалын хичээл"-д сургуулийн нийт сурагчид, багш нар оролцон Өртөөчилсөн тэмцээн зохион явуулав.

Сургуулийн менежер Н.Нямсүрэн багш Н.Уранчимэг, Ө.Буянзаяа нар "Даалгавар боловсруулах арга зүй" сургалт зохион байгуулсан. Уг сургалт 3 цаг үргэлжилсэн бөгөөд сургуулийн нийт багш нар оролцсон. НТБОТ-ийн багш П.Энхбат болон сургалтын менежер Оюунцогзолмаа нар хамтран сумын 0-18 насны нийт хүүхдийн дэлгэрэнгүй судалгаа гаргалаа.

ЕББДС-ийн 9-а ангийн сурагчдын зохион явуулсан өртөөчилсөн тэмцээн явуулж, тэмцээн бага дунд ахлах гэсэн ангиллаар "Илтгэлийн уралдаан", "Буухиа тэмцээн" болсон. "Илтгэлийн уралдаан"-д 1-р байрт 11а ангийн сурагч Хишиг-Эрдэнэ, 2-р байрт 6а анги хамт олон, 3-р байрт 5а анги хамт олон орсон. "Буухиа тэмцээн"-д дунд ангийн хэмжээнд 1-р байранд 7а анги 40 оноогоор, 2-р байранд 5а анги 33 оноогоор, 3-р байранд 4а анги 27 оноогоор тус тус эзэлсэн. Ахлах ангийн дунд 1-р байранд 10а анги 41 оноогоор, 2-р байранд 8а анги 35 оноогоор, 3-р байранд 11а анги 34 оноогоор тус тус эзэлсэн.

"Яргуй" цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт 11-р сарын 27-ны байдлаар бэлтгэл бүлэг 385 хүүхэд 70%, ахлах бүлэг 386 хүүхэд 70%, дунд бүлэг 408 хүүхэд 74%, Бага бүлэг 360 хүүхэд 65% нийт 2200 хүүхэд хүлээн авахаас 1539 хүүхэд авч ирц 70%-тай байна. Сургалт хүмүүжлийн ажлын чиглэлээр Сэлэнгэ аймгийн БСГ, улсын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулсан "СӨБ-н сургалтын цөм хөтөлбөр, үнэлгээ" сургалтанд Ж.Сувд-Эрдэнэ, О.Бямбацэцэг нар хамрагдсан. ОХУ-ын Хиагт хотноо болсон тогооч нарын сургалтанд тогооч Б.Мядагсүрэнг хамруулж, аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулсан ОХУ-ын Буриад улсын Улан-Үдэ хотын "Журавлёнок" цэцэрлэг, "Берёзка" цэцэрлэгийн сургалт хөгжүүлэх үйл ажиллагаатай танилцан хамтран ажиллах шифийн холбоо тогтоолоо.

Тайлант сард ЭМТ-ийн ор хоног 250, эмнэлэгт хэвтсэн 36, нас баралт 1, нийт үзлэгийн тоо 188, үүнээс амбулатори 158, урьдчилан сэргийлэх 1020, идэвхитэй хяналт 30, хяналтанд байгаа жирэмсэн 18, 0-5 настай жинэлсэн хүүхдийн тоо 80, Д амин дэм уусан хүүхэд 10, А амин дэм уусан 120 хүүхэд байна. Түргэн тусламжийн дуудлага 21 ирснээс алсын дуудлага 5 байв. Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 5, чихрийн шижин хэв шинж эрт илрүүлэг үзлэгт 5 хүн, урьдчилан сэргийлэх тарилгад 20 хүүхэд, шинжилгээнд 758 хүн, умайн хавдар хөхний хавдар эрт илрүүлэг үзлэгт 37, элэгний эрт илрүүлэг үзлэгт 5 хүн хамрагджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр 42 хүнд 64,659,840 төгрөг, Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 23 хүнд 19,883,820 төгрөг, жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 67 хүнд 19,415,400 төгрөг, ахмад настаны хөнгөлөлт тусламж 8 хүнд 810,510 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж 1 хүнд 240,000 төгрөг, Эхийн алдар 1,2-р одонтой эхийн тэтгэмж 187 хүнд 24,860,000 төгрөг, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ 36 хүнд 1215.000 төгрөг, алдар цолтой ахмад настан 1 хүнд 1940.000 нийтдээ 365 иргэнд 133.024.570 төгрөгийг олгосон.

Соёлын төвийн өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын нээлтийг хийж Орхон бүсийн соёл урлагийн ажилтнууд, соёлын төвийн дэргэдэх Болор-2 хамтлаг, Сэлэнгэ

аймаг дахь хилийн цэргийн ангийн дуучид оролцсон МУГЖ Энхзул, СТА Чинбаяр нарын “Эх үрийн элбэрэл” аялан тоглолтыг үзэгчдийн хүртээл болголоо. Мөн сурагчдад монгол ёс заншил, уламжлалын талаар танилцуулж, бүжгийн дугуйлан, хөгжмийн дугуйланг 2 ээлжээр хичээллүүлж, 56 хүүхэд хамрагдаж байна. Номын сангаас “Бид чадна” дүрийн тоглолтыг 6-9-р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР